



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

Монгол Улс, 17032, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,
Утас: 77135051,
E-mail: www.emd.gov.mn

2026.04.29 № 61


танай _____-ны № _____-т

┌ ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОЛДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
П.ГАНЗОРИГ ТАНАА

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны болон системчилсэн үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт 93 хуудастай.

ДАРГА



Э.БАТШУГАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2026 он

АГУУЛГА

НЭГ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. ЭМДҮЗ-ийн бүтэц, зохион байгуулалт

1.2. ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТ, ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ

2.1. ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

2.2. Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр

2.3. Хувь хүний халаасны төлбөр

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

3.2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

3.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

3.4. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, зардлын харьцаа

ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2025 ОНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

4.1. Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд, гэрээний хэрэгжилт

4.2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

4.3. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

4.4. Эмийн үнийн хөнгөлөлт

4.5. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

5.1. ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, онцлох шийдвэрүүд

5.2. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

5.3. ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар

5.4. Хууль тогтоомжийн биелэлтийн талаар

5.5. Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

5.6. Сангийн яамнаас эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

6.1. Байгууллагын хүний нөөц

6.2. Эрүүл мэндийн даатгалын хяналт

6.3. Эрүүл мэндийн даатгалын цахимжилт

6.4. Сургалт, сурталчилгааны үр дүн

6.5 Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

7.1. Дүгнэлт

7.2. Анхаарах асуудал, санал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
НББХ	Нийгмийн Бодлогын Байнгын Хороо
ХХНББХ	Хүний Хөгжил Нийгмийн Бодлогын Байнгын Хороо
ЗГ	Засгийн газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
СЯ	Сангийн яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДБ	Эрүүл мэндийн даатгалын байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
ТҮ	Тусламж, үйлчилгээ
ОХБ	Оношийн хамааралтай бүлэг
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТЭМТ	Сум, тосгоны эрүүл мэндийн төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗХХАУБ	Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэл
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2025 он
- Хүснэгт 2. ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр
- Хүснэгт 3. ЭМДҮЗ-ийн 2024 онд баталсан тогтоолууд
- Хүснэгт 4. ЭМДҮЗ-ийн гишүүдийн албан томилолтоор ажилласан мэдээлэл
- Хүснэгт 5. ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2025 он
- Хүснэгт 6. ЭМДС-ийн сангийн зарлагын гүйцэтгэл, 2021-2025 он
- Хүснэгт 7. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2020-2025 он
- Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын хамралт, даатгуулагчийн төрлөөр, 2023-2025 он
- Хүснэгт 9. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2022-2025 он
- Хүснэгт 10. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын гэрээний хэрэгжилт, 2022-2025 он
- Хүснэгт 11. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2025 он
- Хүснэгт 12. ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2025 он
- Хүснэгт 13. Өрх, сум, тосгоноос үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2025 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт
- Хүснэгт 14. СТЭМТ-с үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2025 он
- Хүснэгт 15. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл 2023-2025 он
- Хүснэгт 16. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол болон санхүүжилт, насны багцаар 2023-2025 он
- Хүснэгт 17. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол болон санхүүжилт, даатгуулагчийн төрлөөр 2023-2025 он
- Хүснэгт 18. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрөл 2021-2025 он

Хүснэгт 19. Эмийн үнийн хөнгөлөлт, хөнгөлөлтийн хувиар 2023-2025 он

Хүснэгт 20. Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмж 2021-2025 он

Хүснэгт 21. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт 22. ЭМДЕГ-ын хүний нөөцийн өөрчлөлт, 2022-2025 он

Хүснэгт 23. ЭМДЕГ-ын хүний нөөцийн цалин, урамшуулал, тусламж

Хүснэгт 24. Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал

Хүснэгт 25. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүтэц

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

График 2. Засгийн газрын нийт зардалд Эрүүл мэндийн зардлын эзлэх хувь

График 3. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт

График 4. Эрүүл мэндийн зардалд эзлэх анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь, 2015-2025 он

График 5. Хамтын төлбөрийн хувь, хэмжээ харьцуулсан үзүүлэлт (2021-2025 он)

График 6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлын бүтэц (2020-2025 он)

График 7. Эмзэг бүлгийн иргэдийг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал (тэрбум төгрөгөөр)

График 8. ЭМДС-ийн 2021-2025 оны орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)

График 9. ЭМДС-ийн сангийн тэнцэл (тэрбум төг) 2018-2025 он

График 10. Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр

График 11. ЭМДС-ийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр болон даатгуулагчид ЭМДС-аас зарцуулсан зардлын эзлэх хувь

График 12. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, санхүүжилтэд эзлэх хувь, ТҮ- ний нэр төрлөөр

График 13. Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2025 он, сая төгрөгөөр

График 14 . Эмийн үнийн хөнгөлөлт насны ангилалаар 2023-2025 он (сая төгрөгөөр)

График 15. ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2025 онд зарцуулсан зардал (хувиар)

График 16. 2 сая төгрөгөөс дээш санхүүгийн хамгаалалт авсан иргэдийн тоо ба нийт тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид эзлэх хувь

График 17. Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ авсан нийт хүний тоо 2022-2025 он

График 18. Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоо 2022-2025 он

График 19. Контент хуваалцсан тоо, 2022-2025 он

График 20. Бэлтгэсэн контентын тоо, 2023-2025 он

График 21. Контент хандалтын давхардсан тоо, 2022-2025 он

График 22. ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт

График 23. Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал байдал.

График 24. ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14^{1.1}-т “Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.”, 14^{1.2}-т “Үндэсний зөвлөл нь ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.” гэж тус тус заасан.


Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т зааснаар эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрддэг хуулийн зохицуулалттай.

ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

ЭМДҮЗ нь бүтцийн хувьд Засгийн газрыг төлөөлсөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлсөн 3 гишүүн, нийт 9 гишүүнтэй, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай.

Ажлын алба нь ЭМДҮЗ-ийн 2025 оны 07 дугаар тогтоолоор баталсан бүтэц, орон тооны дагуу 12 орон тоотойгоос 9 орон тоотойгоор 2025 онд үйл ажиллагаа явуулж ирлээ.

1.1. ЭМДҮЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн



Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14^{1.2} дахь хэсэгт зааснаар Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал

болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийж таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг.

Улсын Их Хурлын 2017 оны 40 дүгээр тогтоолоор томилогдсон ЭМДҮЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдыг, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр Б.Алтанхуяг, Т.Баясгалан, С.Эрдэнэбат, ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр Ж.Гэрэлмаа, Ш.Зоригоо, Н.Одонгуа нарыг тус тус томилсон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, ЭМДҮЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ НББХ-нд гаргасан тул Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Б.Рагчааг даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр шинэчлэн томилсон.

1.2. ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа

ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.10-т “Үндэсний зөвлөл нь улиралд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна.” гэж зааснаар 2025 онд 10 удаагийн ээлжит, 1 удаагийн ээлжит бус хуралдаан зохион байгуулж, хуралдааны ирц дунджаар 86.3 хувь байна.

Хүснэгт 1. ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2025 он

Он	Хуралдааны тоо	Хэлэлцсэн асуудал	Баталсан тогтоолын тоо	ЗХХАУБ-д бүртгэгдсэн тогтоолын тоо	Гишүүдийн дундаж ирц
2023	6	15	12	6	80.3%
2024	8	25	16	4	83.2%
2025	11	35	18	3	85.0%
Нийт	25	75	46	13	82.8%

ЭМДҮЗ нь 2025 онд 11 удаа хуралдаж, 35 асуудал хэлэлцэж, 18 тогтоол батлан гаргасан байна.

Хүснэгт 2. ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр

№	Хуралдсан огноо	Гишүүдийн ирц хувь	Хэлэлцсэн асуудлын тоо	Хуралдаанаар баталсан шийдвэрийн тоо
1	2025.01.02	77.7	5	2
2	2025.01.14	88.8	3	3

3	2025.03.17	77.7	3	3
4	2025.04.25	77.7	6	4
5	2025.07.24	100	2	2
6	2025.08.14	88.8	4	3
7	2025.10.27	88.8	2	1
8	2025.11.03	88.8	3	-
9	2025.11.28	88.8	3	-
10	2025.12.22	77	3	1
11	2025.12.30	80	1	1
Нийт			35	18/3

Одоогийн байдлаар ЭМДҮЗ-ийн 2017-2025 оны 30 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

1.3. ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэр

ЭМДҮЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ЭМДҮЗ нь 2025 онд 10 удаагийн ээлжит, 1 удаагийн ээлжит бус хуралдаанаар ЭМД-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 15 тогтоол, өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 3 тогтоол, нийт 18 тогтоол баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 3 актыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд шинээр бүртгүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Хүснэгт 3. ЭМДҮЗ-ийн 2025 онд баталсан тогтоолууд

д/д	Тогтоолын огноо	№	Батлагдсан тогтоол
Нэг. ЭМДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн баталсан тогтоолууд			
1	2025.01.02	01	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай
2	2025.01.02	02	Өгөгдлийн санг төвлөрүүлэх тухай
3	2025.01.14	03	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай (анхан шат)
4	2025.01.14	04	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай (лавлагаа шат)
5	2025.01.14	05	Төлбөрийн хэмжээ, журам шинэчлэн батлах тухай” (урьдчилан сэргийлэх)
6	2025.03.17	09	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай
7	2025.03.17	10	Журам, төлбөрийн хэмжээ батлах тухай

8	2025.03.17	11	Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
9	2025.04.25	12	"Up to date" олон улсын эмнэлзүйн удирдамжийг үргэлжлүүлэн ашиглах тухай
10	2025.08.14	13	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай
11	2025.08.14	14	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам батлах тухай
12	2025.11.03	15	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай
13	2025.12.22	16	Тогтоол хүчингүй болгох тухай (2025 оны 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон)
14	2025.12.22	17	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай
15	2025.12.30	18	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн нарийвчилсан хуваарийг батлах тухай
Хоёр. Дотоод үйл ажиллагаатай холбоотой тогтоол			
16	2025.02.17	06	ЭМДҮЗ-ийн хуралдааны дэг шинэчлэн батлах тухай
17	2025.02.17	07	Ажлын албаны орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл тогтоох тухай
18	2025.02.17	08	Ажлын албаны дүрэм шинэчлэн батлах тухай

1.4. Улсын Их Хуралд ЭМДҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг тайлагнасан тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14¹.2-т “Үндэсний зөвлөл нь ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.” гэж заасны дагуу ЭМДҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг 7 бүлэг, 24 дэд бүлгийн хүрээнд ЭМДС-ийн төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулан судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийж боловсруулан дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг ЭМДҮЗ-ийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, гишүүд саналаа тусгаж, тайланд эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох журмын дагуу системчилсэн үнэлгээ хийж, хууль тогтоомжийн биелэлтийн хамт УИХ-ын НББХ-нд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүргүүлсэн.

ЭМДҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх УИХ-ын НББХ-ны хуралдааныг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Хуралдаанд Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга Ж.Чинбүрэн, ЭМДҮЗ-ийн гишүүн Б.Алтанхуяг, Т.Баясгалан, Ж.Гэрэлмаа, Ш.Зориггоо, Н.Одонгуа болон ажлын албаны дарга, албан хаагчид, Сангийн яам, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын холбогдох газар, хэлтсийн дарга нар оролцсон. Хуралдаанд ЭМДҮЗ-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланг Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга Ж.Чинбүрэн танилцуулж, тайлантай холбогдуулан Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн асуусан асуултад ЭМДҮЗ-ийн гишүүд, холбогдох албан тушаалтнууд хариулт өгч, тайлбар хийж, үйл ажиллагаагаа тайлагнасан.

1.5. ЭМДҮЗ-ийн шийдвэрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцсан тухай

ЭМДҮЗ-ийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг 2025 онд орон нутгийн 21, нийслэлийн 8, нийт 29 эрүүл мэндийн байгууллагуудын бодит нөхцөл байдалтай

танилцаж, нийт 700 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй уулзаж, ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, тулгамдсан асуудлыг сонсож, харилцан санал солилцож ажилласан.

Хүснэгт 4. ЭМДҮЗ-ийн гишүүдийн ЭМБ-д ажилласан байдал

Томилолтоор ажилласан газар	2024 он			2025 он			Нийт	
	ЭМБ-ын тоо	Хаана	Уулзалтад оролцсон хүний тоо	ЭМБ-ын тоо	Хаана	Уулзалтад оролцсон хүний тоо	ЭМБ-ын тоо	Уулзалтад оролцсон хүний тоо
Нийслэл	22	ЭМБ-ын нэр	500	8	ЭМБ-ын нэр	458	30	1008
Улсын эмнэлэг	10	УНТЭ, УХТЭ, СЭМҮТ, ЭНЭҮТ, ХӨСҮТ, Өргөө АГ, ТЗНЭ, БГДЭМТ, БЗДЭМТ, ЧЭМТ, Налайх дүүргийн ЭМТ	500	3	Улсын гуравдугаар төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Сонгино хайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	458	13	458
Хувийн эмнэлэг	4	БЗНЭ, Номун, Дархан детект, Сайнсайхан медицина		5	Рехамед, Бриллиант, ЭМЖЖ, Медвик, Интенсивкаре		9	
Өрхийн ЭМТ	8	Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Налайх дүүргийн тус бүр 2 ӨЭМТ		-	-		8	
Орон нутаг	24	Аймгийн нэр	520	21	Аймгийн нэр	215	45	
ЭМД-ын хэлтэс	4	Баян-Өлгий Төв, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, аймаг	520	3	Хэнтий аймаг, Дорноговь аймаг, Багануур дүүрэг	215	7	735
Аймгийн ЭМГ	3			2			5	
Улсын эмнэлэг	4			4			8	
Хувийн эмнэлэг	4			2			6	
Сум, өрхийн ЭМТ	5			4			9	
Сувилал				3			3	
Эмийн сан	4			3			7	
Нийт	46		1020	29		673	75	1193

Томилолтоор ажилласан тайланг ЭМДҮЗ-ийн хуралдаанд тухай бүр танилцуулж, тулгамдсан асуудлыг бодлогын шийдвэрт тусгаж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

1.6. Хараат бусаар, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хорооны үйл ажиллагааны тухай.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой

байгуулсан нь хараат бус, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах бодит нөхцөлийг бүрдүүлсэн. Техникийн хороо нь:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, чанарын хяналт болон эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, чанарын хяналтын асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач 3;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ санхүүгийн хяналтын асуудлаар мэргэшсэн санхүүгийн шинжээч, судлаач 2;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөл 2;
- Даатгуулагчийн эрх ашгийг төлөөлсөн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл 2 гишүүнээс тус тус бүрддэг.

Мэргэжлийн хувьд хүний их эмч 3, эрүүл мэндийн эдийн засагч 2, эдийн засагч 2, санхүүгийн менежмент 1, хэрэглээний статистикч 1, профессор цолтой 1, дэд профессор цолтой 3, доктор цолтой 4, докторант 1, магистр цолтой 9, гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан 3 гишүүн байна.

2025 онд Техникийн хороо ЭМДҮЗ-ийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2025 оны 03, 04 дүгээр тогтоол, Урьдчилан сэргийлэх, хорт хавдарын эрт илрүүлэгтэй холбоотой 2025 оны 05, 10 дугаар тогтоолуудыг батлахтай холбоотойгоор ажиллаж 226 хуудас бүхий 14 дүгнэлт, 38 зөвлөмж ирүүлсэн байна.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТ, ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ

Дэлхий нийтийн зорьж буй Тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хувьд дараах 4 гол бодлогын зорилтуудын хэрэгжилтийг тооцож ажилладаг. Үүнд:


- Эрүүл мэндийн салбарын улсын зардлын хэмжээг ДНБ-ны 5 хувьд хүргэх, Засгийн газрын зардлын 12 хувьд хүргэх;
- Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй зардлыг ДЭМБ-ын зөвлөж буй жишигт хүргэх буюу ДНБ-ний 1 хувийг анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулах;
- Хувь хүний халаасны төлбөрийн хэмжээг үе шаттай бууруулж, эрүүл мэндийн нийт зардлын 25 хувьд хүргэж бууруулах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах тогтолцоотой болох.

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгалын байгууллага нь хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, иргэдийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудаас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг худалдан авах, гэрээлэх, тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хийж санхүүжүүлэх тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн ялгааг арилган, иргэдэд эрүүл мэндийн улмаас учирч байгаа санхүүгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг шат дараатай авсаар байна.

2.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь: Манай орны хувьд ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2015-2020 он хүртэл 2.7-3.6 хувийн хооронд буюу дунджаар 3.0 хувь тогтмол үзүүлэлттэй гардаг байсан. Харин 2021 онд хамгийн өндөр буюу 4.6 хувьд байгаа нь Коронавируст халдварын өвчлөлд улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгосонтой холбоотой байна. Эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэл хэрэгжсэнээс хойш буюу 2021-2024 онуудад дундаж нь 3.5 болж өссөн бол 2025 онд 3% болж буурсан нь Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 2.0 пунктээр доогуур байна.


График 1. ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь, 2016-2025 он



ЗГ-ын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь: 2015-2020 онд эрүүл мэндийн салбарын зардал өмнөх онтой харьцуулахад жилд дунджаар 8.9 хувиар өссөн байна. Коронавируст халдварын үе буюу 2021 онд эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс нэг удаагийн шинжтэй нэмэлт санхүүжилтүүд хийгдсэнтэй холбоотой залдал 12.8 хувьд хүрсэн нь хамгийн өндөр хувьтай байна.

Тайлант онд Засгийн газрын нийт зардалд Эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 8.5 хувь байгаа нь Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.5 пунктээр доогуур харин өмнөх оноос 0.1 хувиар өссөн дүнтэй байна.

График 2. Засгийн газрын нийт зардалд Эрүүл мэндийн зардлын эзлэх хувь, 2016-2025 он




2.2. Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын Төсвийн тухай хуулиар жил бүр улсын төсвөөс болон гадаадын зээл тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалт, урсгал төсвийн хэмжээг Сайдын багцын төсөвт, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого болон төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-ийн төсөвт тусган тус тус батлан хэрэгжүүлдэг.

2025 онд эрүүл мэндийн улсын зардалд эзлэх ЭМД-ын сангийн зардлын хувь 82.3, эрүүл мэндийн улсын зардалд эзлэх улсын төсвийн шилжүүлгийн хэмжээ 17.7 хувьтай байна.


График 3. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт (тэрбум төгрөг), 2016–2025 он



2021 оноос улсын төсвөөс хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэн, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2020 оноос 4.5 дахин нэмэгдсэн.

Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй зардлын хэмжээ: Анхан шатны тусламж, үйлчилгээний зардлыг 2021 оноос нэг эх үүсвэрээс санхүүжүүлж эхлэхэд эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь 16 хувь байсан бөгөөд Ковидын цар тахлын улмаас 2022 онд хамгийн өндөр буюу 23 хувьд хүрсэн ч 2025 оны байдлаар 19 хувийг эзэлж буурсан байна.


График 4. Эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь, 2016-2025 он



2.3. Хувь хүний халаасны төлбөр

2020 оны байдлаар халаасны төлбөрийн хэмжээ эрүүл мэндийн нийт зардлын 36.4 хувийг эзэлж байна гэсэн судалгаа гарсан тул хувь хүний төлбөрийн хэмжээг 25 хувь хүргэж бууруулах зорилт тавьж, ажилласнаар 2021-2025 оны хооронд дундаж хувь, хэмжээ нь тогтвортой буюу 17%-тай байна. Графикаас харахад үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний хамтын төлбөрийн хэмжээ тогтвортой буюу 17 хувь, төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээний хамтын төлбөрийн хэмжээ 19 -17.4 хувь болсон.


График 5. Хамтын төлбөрийн хувь, хэмжээ харьцуулсан үзүүлэлт: (2021-2025 он)



Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

2.3.1. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хариуцах: Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг илүү өргөжүүлж, иргэний амь нас аврах цочмог үеийн тусламж үйлчилгээг авахад ямар нэгэн хүндрэлгүй болгох, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудыг нэмэгдүүлэх, хамтын төлбөрөөс чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Мөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй амбулаториор эмчлэх шаардлагатай архаг өвчнүүдийг үе шаттай бууруулах, өдрийн эмчилгээг дэмжих, амбулатори, анхан шатруу чиглүүлэх, эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр 2020 онд нийт зардлын 42 хувь нь нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулагдаж байсан бол 2025 онд хамгийн өндөр түвшинд буюу 90 хувь нь нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулсан байна.

График 6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлын бүтэц 2020-2025 он



2.3.2. Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах: Эрүүл мэндийн даатгалын үндсэн зарчим нь эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах бөгөөд шинэчлэлийн хүрээнд төр шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн. Тухайлбал 2021 онд 39 тэрбум, 2022 онд 47 тэрбум төгрөг, 2023 онд 62.8 тэрбум, 2024 онд 76.8 тэрбум, 2025 онд 80.5 тэрбум төгрөгийн хамтын төлбөрийн чөлөөлөлт эдэлсэн байна.

График 7. Эмзэг бүлгийн иргэдийг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал /тэрбум төгрөгөөр/



ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон төрөөс эрүүл мэндийн даатгалын талаар баримтлах бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн орлого, зарлагын тэнцлийг хангах, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

3.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2,464.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2025 оны 01, 13, 15 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарь болон хуваарийн өөрчлөлтийг тус тус баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Орлогын гүйцэтгэл 2.304.1 тэрбум төгрөг, үүнээс ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 977.2 тэрбум төгрөг, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 352.2 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 921.6 тэрбум төгрөг, бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 44.1 тэрбум төгрөг, бусад орлогоос 4.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төсвийн гүйцэтгэл 93.3 хувь байна.


Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан Азийн хөгжлийн банкнаас нэмэлт санхүүжилт 4.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 5. ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2025 он, мян.төгрөг

№	Төсвийн үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	2025 он		
					Төсөв	Гүйцэтгэл	Хувь
САНГИЙН ОРЛОГО		1,219,075.1	1,563,809.7	1,921,743.4	2,464,319.5	2,299,523.0	93.3%
1	Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	487,150.0	616,566.5	812,662.2	1,140,709.0	977,214.9	85.7%
2	Төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	163,708.7	228,117.4	324,113.0	352,203.1	352,203.1	100.0%
3	Төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	540,429.9	687,445.3	746,804.8	921,575.9	921,575.9	100.0%
4	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	25,171.1	29,391.7	34,199.4	49,831.5	44,146.7	88.6%
5	Бусад орлого	2,615.4	2,288.8	3,964.0	0.0	4,382.4	
НЭМЭЛТ ЭХ ҮҮСВЭР		557,679.4	63,910.5	109,485.7		4,593.0	
6	Нэмэлт санхүүжилт	295,335.1	20,000.0	104,082.9		4,593.0	
7	Дансны үлдэгдлээс санхүүжих	262,344.3	43,910.5	5,402.8			
НИЙТ САНХҮҮЖИЛТ		1,776,754.5	1,627,720.2	2,031,229.1	2,464,319.5	2,304,116.0	

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрийн эзлэх хувийг авч үзвэл 42.5 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 40.1 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 15.3 хувийг төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, 1.9 хувийг бусад орлого тус тус эзэлж байна.

График 8. ЭМДС-ийн 2021-2025 оны орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)



3.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар сангийн зарлагыг 2,242.4 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 2,246.2 тэрбум төгрөгийг олгосон байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 2,061,9 тэрбум төгрөг буюу сангийн зарлагын 91.8 хувийг, эмийн үнийн хөнгөлөлтөд 171.1 тэрбум төгрөг буюу сангийн зарлагын 7.6 хувийг, үйл ажиллаганы зардалд 13.2 тэрбум төгрөг буюу сангийн зарлагын 0.6 хувийг, бусад буюу илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 17.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 6. ЭМДС-ийн сангийн зарлагын гүйцэтгэл, 2022-2025 он, мян.төгрөг


№	Төсвийн үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	2025 он	
					Төсөв	Олгосон гүйцэтгэл
	ЗАРЛАГА	1,877,320.4	1,785,446.0	2,129,752.8	2,242,447.3	2,246,230.8
1	Тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,603,425.7	1,635,339.8	1,923,313.5	1,740,532.2	1,745,125.1
2	Эмийн үнийн хөнгөлөлт	80,758.1	99,506.5	137,801.6	171,086.6	171,086.6
3	Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.0	-	-	-	-
4	Үйл ажиллагааны урсгал зардал	13,259.5	10,285.8	15,049.5	13,989.9	13,163.1
5	Эрсдэлийн сан	40,000.0	40,000.0	53,562.6	-	-
6	Бусад	348.5	313.9	25.6	-	17.4
7	ӨМНӨХ ОНЫ ӨГЛӨГ	264,665.0	60,595.9	218,321.7	316,838.6	316,838.6
8	НИЙТ ЗАРЛАГА	2,141,985.4	1,846,041.9	2,348,074.5	2,242,447.3	2,246,230.8

3.1.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл:

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага жил бүр тогтмол өсөж ирсэн ба жилийн дундаж өсөлт 19 хувь байсан бол 2021 оноос эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлтийн хүрээнд улсын төсвөөс олгодог байсан төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-д нэгтгэн нэг эх үүсвэрээс санхүүжүүлдэг болсноор 2020 онтой харьцуулахад ЭМДС-ийн 2025 оны орлого 4.6 дахин, зарлага 4.5 дахин нэмэгдсэн бол 2025 онд ЭМДС-ийн орлого 2,299.5 тэрбум, зарлага 2,246.2 тэрбум байгаа нь өмнөх оноос орлого 377.8 тэрбум төгрөгөөр, зарлага 116.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2025 оны ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолын хүрээнд сангийн тэнцлийг хангах, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тусламж, үйлчилгээнд эрэмбэ тогтоож өөрчлөлтийг хэрэгжүүлсэн. Үүнд олон улсад ашигладаг хатуу хязгаар тогтоох аргыг архаг өвчний тусламж, үйлчилгээнд, цочмог өвчний үед хязгаарлалтгүй, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээнд зөөлөн хязгаар буюу тодорхой түвшинд хүрээд тарифыг 20 хувь бууруулах зохицуулалтыг тусгаж хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өглөг 2021-2025 он



Үүний үр дүнд 2024 онд эрүүл мэндийн байгууллагуудад өгөх өглөг 316.8 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцэст 198 тэрбум төгрөг болж 60 хувиар буурсан байна.

График 9. ЭМДС-ийн сангийн тэнцэл (тэрбум төг), 2018-2025 он



Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын өрөнхий газар

3.2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно” гэж заасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолтой уялдуулан Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан даатгуулагчийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс; түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар буюу 15840 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4 хувиар буюу 31680 төгрөгөөр тогтоож, 2025 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажилласан.

Хүснэгт 7. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2020-2025 он

№	Даатгуулагчийн төрөл	Шимтгэлийн 2020, 2021, 2022 оны хэмжээ	Шимтгэлийн 2023 оны хэмжээ	Шимтгэлийн 2024 оны хэмжээ	Шимтгэлийн 2025 оны Хэмжээ (4-12 сар)
	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	420,000 төгрөг	550,000 төгрөг	660,000 төгрөг	792,000 төгрөг
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь			
2	0-18 насны хүүхэд				
3	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	4200 төгрөг (ХХДХ-ний 1%)	5500 төгрөг (ХХДХ-ний 1%)	6600 төгрөг (ХХДХ-ний 1%)	15840 төгрөг (ХХДХ-ний 2%)
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн	4200 төгрөг (ХХДХ-ний 1%)	5500 төгрөг (ХХДХ-ний 1%)	6600 төгрөг (ХХДХ-ний 1%)	15840 төгрөг (ХХДХ-ний 2%)
5	Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн	8400 төгрөг (ХХДХ-ий 2%)	11000 төгрөг (ХХДХ-ий 2%)	13200 төгрөг (ХХДХ-ий 2%)	15840 төгрөг (ХХДХ-ний 2%)
6	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	8400 төгрөг (ХХДХ-ий 2%)	11000 төгрөг (ХХДХ-ий 2%)	13200 төгрөг (ХХДХ-ий 2%)	31680 төгрөг (ХХДХ-ний 4%)

3.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

2025 онд эрүүл мэндийн даатгалд 3,283.5 мянган даатгуулагч хамрагдаж, нийт хамрагдалт 94.0 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагч 793.5 мянга (24.2%), малчин 37.3 мянга (1.1%), хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 95.5 мянга (2.9%), их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч 54.5 мянга (1.7%), эрүүл мэндийн даатгалыг нь төрөөс хариуцдаг иргэн

2,302.2 мянга (70.1%), гадаадын иргэн 0.9 мянган (0.03%) даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

Эрүүл мэндийн даатгалд 2025 онд хамрагдагсдын тоог өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хамралт 22.6 мянгаар нэмэгдсэн бол өөрөө төлдөг даатгуулагчид буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийн хамралт 22.7 мянгаар, малчны хамралт 13.8 мянгаар тус тус буурч, төр шимтгэлийг нь хариуцдаг даатгуулагч (0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/-ийн хамралтын тоо өмнөх оноос нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын хамралт, даатгуулагчийн төрлөөр, 2023-2025 он

Төрөл	МД	2023 он	2024 он	2025 он	2025/2024 Харьцуу- лалт	Өөрчлөл- тийн хувь
А	Б	1	2	3	4=3-2	5=4/2
1	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.2 дахь хэсэгт заасан ажилтан	788,986	770,923	793,592	22,669	3%
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;	145,867	117,814	95,051	-22,763	-19%
3	Малчин	57,117	51,187	37,387	-13,800	-27%
4	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	667	1,306	854	-452	-35%
5	0-18 насны хүүхэд	1,329,131	1,353,649	1,371,550	17,901	1%
6	Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	538,558	554,674	572,152	17,478	3%
7	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	263,645	274,849	272,497	-2,352	-1%
8	Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	86,357	97,922	75,838	-22,084	-23%
9	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	18,815	42,518	54,507	11,989	28%
10	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	6,021	5,208	5,407	199	4%
11	Ял эдэлж байгаа ялтан	5,055	4,908	4,741	-167	-3%
	Нийт даатгуулагчийн тоо (Мөр 1:11)	3,240,219	3,274,958	3,283,576	8,618	0.3%

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасны дагуу 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагчийн шимтгэлийг улсын төсвөөс төлдөг бөгөөд 2025 оны байдлаар нийт даатгуулагчийн 70.1 хувийг төр даатгалыг нь хариуцах иргэд эзэлж байна.

График 10. Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр



Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын ойлголт, ач холбогдлыг сурталчлан таниулах нээлттэй өдөрлөг, сургалт сурталчилгааны ажлын үр дүнд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан их дээд сургууль болон мэргэжлийн сургалтын төвийн оюутны тоо өмнөх оноос 11.9 мянган даатгуулагчаар нэмэгдэж, хамралтын хувь 28 хувиар өссөн, аж ахуйн нэгж байгууллагын ажилтны хамрагдалт өмнөх оныхоос 22.6 мянган даатгуулагчаар нэмэгдэж, хамралт 3 хувиар өссөн эерэг үр дүнтэй байна.


Нийгмийн даатгалын тухай ерөнхий хууль 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой "Шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэд"-ийн орлогыг эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төвлөрүүлж эхэлсэн бөгөөд энэхүү орлого төвлөрүүлэлтийн үйл ажиллагааг И-монголиа, И-баримт системийг ашиглан бүрэн цахимжуулж, харин цахим хэлбэрээр төлөх боломжгүй иргэдийн асуудлыг арилжааны банкаар дамжуулан төлүүлсэн. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчид нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай үедээ эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлдөг буруу зан үйл, хандлагаас шалтгаалан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдын хамралт өмнөх оноос буурсан байна.

3.4. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээ авсан зардлын харьцаа

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан үзэхэд:

- Цалин түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь нийт даатгуулагчийн 24.2 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 71.1 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 14.1 хувийг эзэлж байна.
- Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 70.1 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 25.6 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 76.2 хувийг эзэлж байна.
- Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагч нь нийт даатгуулагчийн 5.7 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 3.2 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 9.8 хувийг эзэлж байна.

График 11. Даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн орлого, зардлын эзлэх хувь



2025 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын 76.2 хувь нь төр шимтгэлийг нь хариуцан төлдөг даатгуулагч, 14.1 хувь нь цалин, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа даатгуулагч, 9.8 хувь нь шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд тус тус зарцуулагдсан байна.

Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтан хамаардаг бөгөөд нийт 2.3 сая гаруй даатгуулагчийн шимтгэлийг төрөөс хариуцдаг. Эдгээр иргэд нь нийт шимтгэлийн орлогын 25.6 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 76.2 хувийг эзэлж байгаа нь зарлага нь орлогоос 2.9 дахин их байна.

ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2025 ОНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

4.1. Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд, гэрээний хэрэгжилт:

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-д нэгдсэн сонгон шалгаруулалтыг гурван жилд зохион байгуулахаар тусгасан.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 13, 2023 оны 07 дугаар тогтоолын дагуу лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай даатгалын гэрээг 3 жилийн хугацаатай байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх гэрээг “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 05, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг эрүүл

мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журмын дагуу 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллага тус бүртэй өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний хүрээнд хэлэлцээр хийж, гэрээ байгуулан ажиллалаа.

Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2025 онд гэрээ үргэлжлүүлэн байгуулах 298, шинээр гэрээ байгуулах 23, нийт 321 эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, тоног төхөөрөмж, тусгай нэгж байгууламжийн мэдээллийг сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн www.selection.1818.mn-д шинэчлүүлэх тухай зарыг байгууллагын цахим хуудаст байршуулж, лавлагаа шатлалын Эрүүл мэндийн байгууллага бүрт 2024 оны 05/4367 дугаартай, 2025 оны 05/225 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлж, мэдээллийг шинэчлүүлсэн. Тус хүчин чадлын мэдээлэл болон аймаг, нийслэлийн ор баталсан тушаалууд, тухайн эрүүл мэндийн байгууллагаас амбулаторийн кабинет, эмчийн мэдээлэл зэргийг нэмэлтээр тодруулан судалж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны Журам батлах тухай А/56 дугаар тушаалын аргачлалын дагуу гэрээт 298, шинэ сонгон шалгаруулалтад тэнцсэн 25, нийт 325 эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадлыг тооцоолсон. Лавлагаа шатлалын 311 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласан бөгөөд 2025 оны 10 сарын 01-ний өдрөөс төрийн өмчийн 84 эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн 17 эрүүл мэндийн байгууллагатай тус тус гэрээ байгуулан ажилласан.

Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж, үйлчилгээг нийт 1550 эмийн сантай байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.

Хүснэгт 9. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2022-2025 он

ЭМБ төрөл	2022 он	2023 он	2024 он	2025 он	2025/2024 өөрчлөлт
Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага	322	320	320	312	-8
Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	532	546	552	555	3
Эмийн сан	1,462	1,484	1513	1550	37
Нийт гэрээт эрүүл мэндийн байгууллага	2,316	2,350	2385	2417	32

Лавлагаа шатлалын 312 эрүүл мэндийн мэндийн байгууллага гэрээний гүйцэтгэлийг үнэлүүлснээс нийслэлийн 172 ЭМБ-ын 102 нь маш сайн, 53 нь хангалттай, 1 хангалтгүй, 16 эрүүл мэндийн байгууллага холбогдох материалыг ирүүлээгүй байна. Харин орон нутагт 140 ЭМБ гэрээний гүйцэтгэлийг үнэлүүлснээс 119 нь маш сайн, 19 нь хангалттай, 2 ЭМБ холбогдох материалыг ирүүлээгүй байна.

Анхан шатны 555 эрүүл мэндийн байгууллагын 2025 оны гэрээний гүйцэтгэлийн үнэлгээ Маш сайн буюу 90 ба түүнээс дээш үнэлгээтэй 268 анхан шатны эрүүл мэндийн байгууллага, Хангалттай буюу 70 ба түүнээс дээш үнэлгээтэй 233 анхан шатны эрүүл мэндийн байгууллага, Хангалтгүй буюу 69.9 ба түүнээс доош үнэлгээтэй 54 анхан шатны эрүүл мэндийн байгууллага байна.

Улсын хэмжээнд нийт 1550 /нийслэлийн 746, орон нутгийн 804/ эмийн гэрээний биелэлтийг үнэлүүлэхээс 1458 эмийн сан материалаа заасан хугацаанд ирүүлж гэрээгээ дүгнүүлсэн бол 92 эмийн сан гэрээ дүгнүүлэх материалаа ирүүлээгүй байна. Гэрээний биелэлтээ үнэлүүлсэн 1458 эмийн сангаас 80-с дээш оноотой үнэлэгдсэн 1319 эмийн сангийн /нийслэл 584, орон нутгийн 735/, 60-79.9 оноогоор үнэлэгдсэн 124 эмийн сангийн /нийслэл 102, орон нутаг 22/, 59.9-с доош оноотой үнэлэгдсэн 15 эмийн сан /нийслэл 6, орон нутаг 9/ байна.

Хүснэгт 10. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын гэрээний хэрэгжилтийн үнэлгээ 2025 он

№	ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал	2025 он	Гэрээний биелэлтийн үр дүн			
			90 ба түүнээс дээш үнэлгээтэй (Маш сайн)	70 ба түүнээс дээш үнэлгээтэй (Хангалттай)	69.9 ба түүнээс доош үнэлгээтэй (Хангалтгүй)	Материал ирүүлээгүй
1	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	80	221 /70.8%/	72 /22.4%/	1 /0.3%/	18 /5.7%/
2	Хувийн эмнэлэг	226				
3	Рашаан сувилал	6				
4	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв	555	268 /48%/	233 /42%/	54 /10%/	
	ЭМБ-ын төрөл	1550	80 ба түүнээс дээш үнэлгээтэй /Гэрээ үргэлжлэх/	60-79.9 оноотой /гэрээ түдгэлзүүлэх /	59.9 доош буюу /гэрээ дуусгавар болгох/	Материал ирүүлээгүй
5	Эмийн сан	1550	1319 /85.0%/	124 /8.0%/	15 /0.9%/	92 /5.9%/
	Нийт	2385	1465 /61.4%/	671 /28.1%/	153 /6.4%/	92 /3.8%/

4.2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

2025 онд ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын хүрээнд лавлагаа шатлалын болон сумын эрүүл мэндийн төвийн зарим тусламж, үйлчилгээг зохицуулж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгон ажиллав. Энэхүү тогтоолын хүрээнд улсын хэмжээнд нийт гэрээ бүхий 314 эрүүл мэндийн байгууллагууд иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, тусламж, үйлчилгээг үзүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллага давхардсан тоогоор 10.5 сая тусламж, үйлчилгээг худалдан авч, 1,360.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

Нийт 10.5 сая тохиолдлын 90.8 хувь буюу 9.6 сая нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас, 8.6 хувь буюу 914.6 мянга нь хувийн хэвшлийн эмнэлгээс, 0.5 хувь буюу 57.9 мянга тохиолдлыг сувиллаас үзүүлсэн байна.

Нийт санхүүжилт болох 1,360.0 тэрбум төгрөгийн 1,177.0 тэрбум (86.6%) төгрөгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад, 165.7 тэрбум (12.2%)

төгрөгийг хувийн хэвшлийн эмнэлэгт, 17.1 тэрбум (1.3%) төгрөгийг сувиллаас үзүүлсэн тусламж, үйлчилгээнд олгосон байна.

ЭМДС-аас 2025 онд олгосон санхүүжилтийн 57.5 хувь (782.4 тэрбум төгрөг) нь хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд, 21.7 хувь (294.9 тэрбум төгрөг) нь амбулаторийн тусламж, үйлчилгээнд, 6.5 хувь (88.5 тэрбум төгрөг) өдрийн эмчилгээнд олгогдсон байна. Бусад тусламж, үйлчилгээнд 58.5 саяас 28.4 тэрбум төгрөгийг олгосон нь санхүүжилтийн 0.001-2.1 хувийг эзэлж байна. Харин тусламж, үйлчилгээний тохиолдлын тоогоор авч үзвэл нийт тохиолдлын тооны 68.6 хувь (7.2 сая) нь амбулаторийн тусламж, үйлчилгээ, 9.4 хувь (993.8 мянга) нь яаралтай тусламж, үйлчилгээ, мөн 6.0 хувь (629.8 мянга) нь хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ байна.


Хүснэгт 11. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2025 он

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2024 он		2025 он					
		Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тооны өөрчлөлт		Санхүүжилтийн өөрчлөлт	
						Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	722,238	796,955.6	629,868	782,433.7	-92,370	-12.8%	-14,522	-1.8%
	1.1. Мэс засал	171,550	331,563.6	149,099	309,542.4	-22,451	-13.1%	-22,021	-6.6%
	1.2. Эмийн эмчилгээ	519,283	366,326.9	444,070	352,607.2	-75,213	-14.5%	-13,720	-3.7%
	1.3. Эрчимт эмчилгээ	17,509	62,654.4	20,940	85,564.7	3,431	19.6%	22,910	36.6%
	1.4. Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ	13,736	22,231.6	15,584	19,857.0	1,848	13.5%	-2,375	-10.7%
	1.5. Эрхтэн шилжүүлэх мэс засал	160	14,178.9	175	14,862.4	15	9.4%	684	4.8%
2	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	7,417,854	300,086.9	7,264,133	294,995.1	-153,721	-2.1%	-5,092	-1.7%
	2.1. Амбулаторийн үзлэг	3,633,276	83,459.7	3,396,748	71,944.4	-236,528	-6.5%	-11,515	-13.8%
	2.2. Амбулаторийн үзлэг оношилгоо шинжилгээний багц	2,151,156	142,854.2	2,012,493	150,091.2	-138,663	-6.4%	7,237	5.1%
	2.3. Амбулаторийн хяналтын үзлэг	1,046,411	38,930.9	1,095,434	35,422.9	49,023	4.7%	-3,508	-9.0%
	2.4. Амбулаториор хийгдэх мэс ажилбар	66,167	2,598.3	66,953	2,125.6	786	1.2%	-473	-18.2%
	2.5. Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	368,887	23,693.2	290,827	16,986.4	-78,060	-21.2%	-6,707	-28.3%
	2.6. Жирэмсний хяналт	151,957	8,550.5	158,493	12,249.8	6,536	4.3%	3,699	43.3%
	2.7. Сэтгэл зүйн үзлэг, зөвлөгөө			243,185	6,174.9				
3	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	323,533	28,126.8	174,167	23,480.4	-149,366	-46.2%	-4,646	-16.5%
4	Өдрийн эмчилгээ	156,290	56,979.0	115,370	44,798.0	-40,920	-26.2%	-12,181	-21.4%
	4.1. Өдрийн мэс засал	12,970	4,492.6	10,321	3,956.2	-2,649	-20.4%	-536	-11.9%
	4.2. Өдрийн эмийн эмчилгээ	112,895	30,032.1	68,944	18,857.1	-43,951	-38.9%	-11,175	-37.2%

	4.3.Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ	20,652	9,369.3	23,835	14,613.4	3,183	15.4%	5,244	56.0%
	4.4. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ	9,773	13,084.9	12,270	7,371.2	2,497	25.5%	-5,714	-43.7%
5	Диализын тусламж, үйлчилгээ	251,032	38,703.0	274,762	43,731.7	23,730	9.5%	5,029	13.0%
	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	300,701	36,519.3	310,269	26,204.8	9,568	3.2%	-10,315	-28.2%
6	6.1.Амбулаторийн үзлэг	237,392	5,036.5	266,350	5,514.5	28,958	12.2%	478	9.5%
	6.2.Өдрийн эмчилгээ	20,561	5,865.3	35,343	12,193.6	14,782	71.9%	6,328	107.9%
	6.3.Хэвтүүлэн эмчлэх	42,748	25,617.5	8,576	8,496.7	-34,172	-79.9%	-17,121	-66.8%
	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	321,516	45,688.1	195,803	28,458.3	-125,713	-39.1%	-17,230	-37.7%
7	7.1.Амбулаторийн үзлэг	227,848	4,884.4	140,258	3,059.5	-87,590	-38.4%	-1,825	-37.4%
	7.2. Өдрийн эмчилгээ	24,230	4,052.0	13,384	2,306.2	-10,846	-44.8%	-1,746	-43.1%
	7.3.Хэвтүүлэн эмчлэх	69,438	36,751.8	42,161	23,092.6	-27,277	-39.3%	-13,659	-37.2%
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	8,849	8,564.10	11,785	13,074.3	2,936	33.2%	4,510	52.7%
9	Яаралтай тусламж	920,547	56,358.70	993,858	53,238.7	73,311	8.0%	-3,120	-5.5%
10	Түргэн тусламж	552,601	32,576.80	553,542	32,606.2	941	0.2%	29	0.1%
11	Телемедициний тусламж, үйлчилгээ	712	38.4	1,006	58.5	294	41.3%	20.1	52.3%
	Сувиллын тусламж, үйлчилгээ	75390	21254.2	59,277	17,306.1	-16113	-21.4%	-3948.1	-18.6%
	Нийт дүн	11,051,263	1,421,850.8	10,583,840	1,360,385.8	-467,423	-4.2%	-61,465	-4.3%

Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоонд эзлэх хувийг харахад хамгийн өндөр нь амбулаторийн тусламж, үйлчилгээ 68.6 хувийг эзэлж байгаа нь амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний 8 багцыг шинээр үүсгэж, амбулаторийн тусламж, үйлчилгээний тарифыг 20 хувиар нэмэгдүүлсэн бодлогын өөрчлөлттэй холбоотой.

График 12. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, санхүүжилтэд эзлэх хувь, ТҮ- ний нэр төрлөөр



4.2.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ: Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний 629.8 мянган тохиолдолд 782.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээ тохиолдлын тооны 64.5 хувь (406.0 мянга), санхүүжилтийн 39.9 хувь (312.5 тэрбум төгрөг)-ийг, мэс заслын тусламж, үйлчилгээ тохиолдлын тооны 23.7 хувь (149.0 мянга), санхүүжилтийн 39.6 хувь (309.5 тэрбум төгрөг)-ийг эзэлж байна.

Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээнд 15.5 мянган тохиолдолд 19.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Эрхтэн шилжүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээний 175 хүнд 14.8 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд дундаж зардал 84.9 сая төгрөг байна. Эрчимт эмчилгээний 20.9 мянган тохиолдолд 85.5 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд нэг тохиолдлын дундаж зардал 4.0 сая төгрөг байна.

4.2.2. Амбулаторийн тусламж, үйлчилгээ ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний өндөр өртөгтэй болон энгийн багцыг дахин зохион байгуулж, өндөр өртөгтэй болон энгийн багцыг нэгтгэн бүлэглэсэн. Мөн өөр эрүүл мэндийн байгууллагад хийсэн оношилгоо, шинжилгээг ашиглан амбулаторийн цогц тусламж, үйлчилгээг үзүүлсэн тохиолдолд багцын төлбөрийн хэмжээг тооцохдоо тухайн оношилгоо, шинжилгээний төлбөрийн хэмжээг 20 хувиар тооцон гаргасан бодит зардлыг нэмэгдүүлэн тооцож санхүүжүүлэх зохицуулалт оруулсан. Амбулаторийн хяналтын багцыг оновчтой болгох, эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийг зөв үүсгэх, тогтвортой хяналтыг бий болгох зорилгоор үзлэгийн тарифын өртгийг 10-40 хувиар нэмэгдүүлсэн.

Амбулаторийн тусламж, үйлчилгээний 7.2 сая тохиолдолд 294.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Амбулаторийн үзлэгийн 3.3 сая тохиолдолд 71.9 тэрбум төгрөг олгохоор тооцсон нь амбулаторийн нийт тусламж, үйлчилгээний тохиолдлын 46.8 хувь, санхүүжилтийн 24.4 хувийг ,амбулаторийн үзлэг, оношилгоо шинжилгээний багцын тусламж, үйлчилгээнд 2.0 сая тохиолдолд 150.0 тэрбум төгрөгийг олгосон нь тохиолдлын тооны 27.7 хувь, санхүүжилтийн 50.9 хувийг тус тус эзэлж байна.

Амбулаторийн хяналтын үзлэгийн 1.0 сая тохиолдолд 35.4 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон нь нийт үзлэгийн тооны 15.1 хувийг эзэлж байна. Жирэмсний хяналтын багц 158.4 мянган тохиолдолд 12.2 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон нь нийт тохиолдлын 2.2 хувийг, санхүүжилтийн 4.2 хувийг эзэлж байна.

4.2.3. Өдрийн эмчилгээ: Өдрийн эмчилгээний нийт 115,3 мянган тохиолдолд 44.7 тэрбум төгрөгийг олгосон байна. Өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 8.9 хувь, санхүүжилтийн 8.8 хувийг эзэлж байгаа бол өдрийн эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 59.8 хувь, санхүүжилтийн 42.1 хувийг эзэлж байна. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ тохиолдлын 10.6 хувь, санхүүжилтийн 16.5 хувийг эзэлж байна.

4.2.4. Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ: 2025 онд өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд 323.5 мянган тохиолдолд 28.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгосон байна.

4.2.5. *Яаралтай тусламж*: Яаралтай тусламж, үйлчилгээний нийт 993,8 мянган тохиолдолд 53.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

4.3. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 онд анхан шатны 555 эрүүл мэндийн байгууллагуудад 513.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон байна. Үүнээс сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 330 эрүүл мэндийн байгууллагуудад 284.9 тэрбум төгрөгийг, өрхийн эрүүл мэндийн төвийн 225 гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 228.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 12.ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2025 он

№	Анхан шатны тусламж, үйлчилгээ	2023 он	2024 он	2025 он	Өөрчлөлт /2025-2024/	
					Тоогоор	Хувиар
1	Сум, тосгоны ЭМТ-с үзүүлэх тусламж, үйлчилгээ	50,290.40	87,417.3	68,028.1	-19,389.2	-22.2%
1.1	Хэвтүүлэн эмчлэх	30,073.40	48,572.60	34,237.30	-14,335.3	-29.5%
1.2	Түргэн тусламж	11,231.70	21,465.10	19,371.50	-2,093.6	-9.8%
1.3	Яаралтай тусламж	5,109.80	10,336.20	7,623.90	-2,712.3	-26.2%
1.4	Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	3,875.50	7,043.40	6,795.40	-248.0	-3.5%
2	Өрх, сум тосгоны ЭМТ-с үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээ	34,083.70	54,526.2	46,217.5	-8,308.7	-15.2%
2.1	Сэргээн засах	9,489.80	14,040.5	12,654.7	-1,385.8	-9.9%
2.1	Өдрийн эмчилгээ	11,343.30	17,506.9	14,392.8	-3,114.1	-17.8%
2.2	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	3,762.50	6,023.1	6,467.6	444.5	7.4%
2.3	Оношилгоо, шинжилгээ	9,488.00	16,955.7	12,702.4	-4,253.3	-25.1%
3	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний санхүүжилт	274,924.40	345,502.50	399,434.4	53,931.9	15.6%
	Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал	359,298.60	487,446.00	513,680.0	26,234.0	5.4%

Нэг иргэнээр тооцсон багц тусламж, үйлчилгээний 2025 оны гүйцэтгэлийг авч үзвэл 20.5%-ийг эмчлэхэд, 31.7%-ийг Халдварт бус өвчний эрт илрүүлэгт, 33.0%-ийг эрүүл мэндийг хянахад, 6.7%-ийг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөхөд, 4.1%-ийг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд, 0.001%-ийг эрүүл мэндийн дэмжихэд, 3.3%-ийг халдварт өвчний эрт илрүүлэгт, 0.7%-ийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 0.02%-ийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ тус тус хийсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, зарим сэргээн засах тусламж, үйлчилгээнд 2025 оны байдлаар 1.1 сая тохиолдолд 46.2 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон байна. Нийт санхүүжилтийн 44.4 тэрбум төгрөг буюу 96.2 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 1.7 тэрбум төгрөг буюу 3.8 хувийг сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. Өрх, сум, тосгоноос үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2025 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр

№	Тусламж, үйлчилгээний төрөл	ӨЭМТ		СТЭМТ		Нийт			
		Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо		Санхүүжилт	
1	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	66,471	6,239.4	3,156	228.2	69,627	5.9%	6,467.6	14.0%
2	Оношилгоо, шинжилгээ	785,069	11,978.7	47,253	723.7	832,322	70.1%	12,702.4	27.5%
3	Өдрийн эмчилгээ	123,732	13,984.7	3,450	408.1	127,182	10.7%	14,392.8	31.1%
4	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	153,457	12,275.4	4,741	379.3	158,198	13.3%	12,654.7	27.4%
Нийт дүн		1,128,729	44,478.3	58,600	1,739.3	1,187,329	100%	46,217.6	100.0%

Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нь авч үзвэл нийт тохиолдлын 3.8 хувийг сум, тосгоны эрүүл мэндийн төв, 96.2 хувийг өрхийн эрүүл мэндийн төв тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг насны ангиллаар нь харвал 65 аас дээш насны даатгуулагчид хамгийн их тусламж, үйлчилгээ авсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагаар нь задалбал өрхийн эрүүл мэндийн төв 95.5 хувь нь, сум тосгоны эрүүл мэндийн төв 4.5 хувь нь тус тус тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хийгдэж буй өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр нь харвал тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд 47.6 хувийг, ААН, төсөвт байгууллагын ажилтан 12.5 хувийг, 0-18 насны хүүхдүүд 23.9 хувийг тус тус эзэлж байгаа бол нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа, зайлшгүй шаардлагатай иргэд 8.4 хувийг эзэлж байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвд өдрийн эмчилгээ авсан даатгуулагчдын 42.7 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, 17.6 хувийг ААН, төсөвт байгууллагын ажилтан эзэлж байгаа бол 0-18 насны хүүхэд 16.1 хувийг эзэлж байна. Өрхийн эрүүл мэндийн төвд өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдын 16 хувь нь 0-18 насны хүүхдүүд байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаас доорх тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байна. 2025 оны байдлаар 476.6 мянган тохиолдолд 68.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна. Нийт санхүүжилтийн 50.3 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, 28.5 хувийг түргэн тусламж, үйлчилгээ, 11.2 хувийг яаралтай тусламж, үйлчилгээ, 10.0 хувийг шүд амны хөндийн тусламж, үйлчилгээ тус тус эзэлж байна.

Хүснэгт 14. СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2025 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тохиолдлын тоо	Хувиар	Санхүүжилт	Хувиар
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	89,433	18.8%	34,237.3	50.3%
2	Түргэн тусламж	127,792	26.8%	19,371.5	28.5%
3	Яаралтай тусламж, үйлчилгээ	103,848	21.8%	7,623.9	11.2%
4	Шүд амны хөндий	155,580	32.6%	6,795.4	10.0%
Нийт		476,653	100.0%	68,028.1	100.0%

4.4. Эмийн үнийн хөнгөлөлт


Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ”-г мөрдөж байна.

2025 онд 1550 эмийн сангаар дамжуулан эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 864.6 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 171.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 81.9 мянган хүнээр нэмэгдэж, санхүүжилт 27.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 15. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт 2022-2025 он, сая төгрөгөөр

Төсөв, гүйцэтгэл	2023 он	2024 он	2025 он	Өөрчлөлт /2025-2024/	
				Тоогоор	Хувиар
Төсөв /сая.төг/	89,982.5	137,801.6	171,086.6	33,285.0	24.2%
Гүйцэтгэл /сая.төг/	99,506.5	134,549.6	171,086.0	36,537.0	27.2%
Хамрагдсан хүний тоо	645,360	784,827	864,615.0	79,788	10.2%


График 13. Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2025 он, сая төгрөгөөр



Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд 2025 онд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 68.1 хувийг эзэлж байгаа бол хугацаат цэргийн албан хаагч, хүүхдээ асарч буй эх/эцэг, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, ял эдэлж байгаа ялтан санхүүжилтийн хамгийн бага хувийг буюу 0 - 0.03 хувийг эзэлж байна.

Хөнгөлөлттэй эмийн хэрэглээг насны бүлгээр нь авч үзвэл 55-аас дээш насны хүн ам нийт хөнгөлөлт авсан даатгуулагчийн хүн амын 40.9 хувийг эзэлж байгаа нь тус насны бүлгийн хүн амд эмийн хэрэглээ өндөр байна.

График 14. Эмийн үнийн хөнгөлөлт насны ангилалаар 2023-2025 он, сая төгрөгөөр



4.5. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1-т “Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж байна.

2025 оны байдлаар улсын хэмжээнд 18-аас дээш насны хүн амын 17.1 хувь буюу 152,703 хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдаж 25.3 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна.

Хүснэгт 16. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт, насны багцаар 2023-2025 он

Багц	2023 он		2024 он		2025 он		Өөрчлөлт /2025-2024/	
	Тохиолдол	Санхүүжилт	Тохиолдол	Санхүүжилт	Тохиолдол	Санхүүжилт	Тохиолдол	Санхүүжилт
18-30 насны багц	60,656	3,625.9	37,468	3,104.4	25,693	2,271.9	-11,775	-832.5
31-45 насны багц	130,514	16,067.7	89,200	13,105.0	55,818	10,048.1	-33,382	-3,056.9
46-60 насны багц	113,701	16,044.3	62,880	10,865.3	46,316	8,798.5	-16,564	-2,066.8
61+дээш насны багц	52,516	6,905.0	29,658	4,551.7	24,876	4,245.0	-4,782	-306.7
Нийт	357,387	42,642.9	219,206	31,626.3	152,703	25,363.4	-66,503	-6,262.9

Хамралтыг насны ангиллаар авч үзвэл 18-30 насны залуучуудын 15.2 хувь, 31-45 насны хүн амын 17.6 хувь, 46-60 насны 17.2 хувь, 61-ээс дээш насны хүн амын 18.2 хувь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан дүнтэй байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн 56.6 хувь нь Улаанбаатар хотод, 43.4 хувь нь хөдөө орон нутагт байршилтай эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн байна.

Эрт илрүүлэгт хамрагдалтыг даатгуулагчийн төрлөөр авч үзвэл нийт хамрагдсан хүний 32 хувийг ажил хөдөлмөр эрхэлдэг иргэд, 51 хувийг шимтгэлийг нь төр хариуцах иргэд, 15 хувийг шимтгэлээ өөрөө төлөгч малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, оюутан суралцагсад эзэлж байна.

Хүснэгт 17. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт, Даатгуулагчийн төрлөөр 2023-2025 он

№	Даатгуулагчийн төрөл	2025 он			
		Тохиолдол		Санхүүжилт	
		Тоо	Хувь	Сая/төг/	Хувь
1	Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	47,164	30.9%	8,381.9	33.0%
2	Цалин, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлдөг иргэн	50,193	32.9%	8,229.5	32.4%
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	21,318	14.0%	3,397.8	13.4%
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	10,522	6.9%	1,826.6	7.2%
5	Малчин	5,521	3.6%	1,001.3	3.9%
6	Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэлж нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	5,924	3.9%	892.9	3.5%
7	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	8,136	5.3%	1,276.4	5.0%
8	0-18 насны хүүхэд	3,803	2.5%	339.7	1.3%
9	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	75	0.0%	13.1	0.1%
10	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	46	0.0%	4.1	0.0%
11	Хорих	1	0.0%	0.1	0.0%
	Нийт	152,703	100%	25,363.4	100%

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНЫ ШИНЭЧЛЭЛ

УИХ-аас 2020 онд Эрүүл мэндийн мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиудад өөрчлөлт орж, улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санг нэгтгэж, нэг худалдан авалтын тогтолцоонд шилжсэн.

Стратегийн худалдан авагчийн тогтолцоо нь байгаа нөөцийн хүрээнд хамгийн үр дүнтэй, үр ашигтай тусламж, үйлчилгээг худалдан авах бодлого хэрэгжүүлэх бөгөөд үүнд нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг багцад хамруулах, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх хамгийн сайн эрүүл мэндийн байгууллагыг сонгож гэрээлэх, тусламж, үйлчилгээний үр ашиг, чанарт чиглэсэн төлбөрийн аргаар

худалдан авч, чанар үр ашиг, хүн амын эрүүл мэндийн үр дүнг сайжруулах зорилгод чиглэгдэж ирлээ.

Үүний хүрээнд өнгөрсөн хугацаанд ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 тогтоол, 2023 оны 06, 2025 оны 03 дугаар тогтоолуудыг тус тус батлан, тухай бүр багцийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, орон нутагт ажиллах урамшууллыг бий болгох зэрэг бодлогын өөрчлөлтүүдийг үе шаттай хэрэгжүүлж ирсэн.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны үр дүнг сайжруулахаар Засгийн газрын зүгээс Азийн хөгжлийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын техник туслалцааны төсөл хэрэгжүүлж, өнгөрсөн 5 жилийн хугацаанд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулж, бодлогын баримт бичиг боловсруулах, тооцоолол, судалгаа хийх, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг авч ажиллалаа.

5.1 ЭМДҮЗ-ийн онцлох шийдвэрүүд

5.1.1. ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлж, анхан шатны тусламж, үйлчилгээг илүү хүн амын эрэлт хэрэгцээнд суурилан хөгжүүлэх, тусламж, үйлчилгээний тэгш байдлыг хангаж шинэчиллээ.

- ✓ 0-18 насны хүүхдүүд, 80-аас дээш ахмадууд болон, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэх үүднээс гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээний багцуудад илүү зорилтот бүлэгт чиглэсэн багцуудыг гаргасан.
- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар өсгөж, орон нутгийн 40 хувийн цалингийн нэмэгдлийн тохируулга хийж тусгалаа.
- ✓ Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хүүхдийн өдрийн эмчилгээний багцийг шинээр үүсгэж, хэрэгжүүлсэн үр дүнг тооцож, өдрийн эмчилгээнд зарцуулах төсвийн 40-өөс доошгүй хувийг хүүхдийн өдрийн эмчилгээнд зарцуулахаар журамласан.
- ✓ Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж, нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар үзүүлж буй эх, нярайн гэрийн идэвхитэй эргэлтийг давхар санхүүжүүлэхээр зохицуулсан.
- ✓ Сувиллаас үзүүлэх хүүхдийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг шинээр үүсгэж анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас илгээх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага үзүүлэх боломжоор хангасан.

5.1.2. ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор эх хүүхдийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг бодлогоор дэмжин, дурангын мэс заслыг дэмжих оношийн хамааралтай бүлгийг бий болгож, амбулаторийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгүүдийг шинэчиллээ.

- ✓ Монгол Улсын хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын чиглэлээр кесаров зүслэгээр эхийг төрүүлэхээс бусад төрлийн эх барихын тусламж,

- үйлчилгээг 80 хүртэлх хувиар, нярайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээг 20 хувиар, хүүхдэд үзүүлэх мэс заслын болон эмийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээг 10 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг сайжруулах үүднээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн судалгаанд үндэслэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг амбулаторийн тусламж, үйлчилгээний багцад нэгтгэж, багцыг өргөтгөлөө.
- ✓ Амбулаторийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг дахин зохион байгуулж, нийт оношилгоо шинжилгээг багцлан амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ болгон оношийн хамааралтай бүлэг болгосон.
 - ✓ Хор хөнөөл багатай орчин үеийн дэвшилтэт технологи болох дурангийн оношийн хамааралтай бүлгийг нээлттэй мэс заслын оношийн хамааралтай бүлгээс салгаж, 54 оношийн хамааралтай бүлэг үүсгэсэн. Тарифын хувьд бодит өртгийг тооцсоны үндсэн дээр 10 хувиар нэмэгдүүлсэн.

5.1.3. Сангийн тэнцлийг хангах үүднээс эрүүл мэндийн даатгалын сангийн чадамжид нийцсэн тусламж, үйлчилгээг худалдан авах нөхцөлийг бүрдүүллээ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээний өсөлт нь сангийн жилийн төсвөөс давж буй учраас 2023-2024 онд үүссэн өр төлбөрийг үе шаттай бууруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс эмнэлгийн тусламж, үйлчилгээг цочмог өвчний үеийн тусламж, үйлчилгээ, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээ, архаг өвчний үеийн тусламж, үйлчилгээ гэж бүлэглэсэн. Тус өөрчлөлтийн дагуу цочмог үеийн амь нас аврах тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх бол төлөвлөгөөт тусламж, үйлчилгээг гэрээгээр урьдчилан тохиролцож, хэрэв гэрээний дүн хэтэрсэн тохиолдолд төлбөрийн хэмжээний 80 хувиар санхүүжүүлэх, архаг өвчний үеийн тусламж, үйлчилгээг сангийн мөнгөн хөрөнгийн байдалд үндэслэн тодорхой хэмжээгээр худалдах авах ба хэрэв тоо хэмжээ дууссан бол иргэнээс төлбөр авах эрхийг нээж өгсөн.

5.1.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хүрээнд хорт хавдраас урьдчилан сэргийлэх оношилгоо шинжилгээнд зорилтот бүлгийг хамруулах, эмгэг илэрсэн тохиолдолд бүртгэж, шаардлагатай эмчилгээ, хяналтыг хэрэгжүүлэхээр шинэчиллээ.


Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр тушаалтай уялдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Журам, төлбөрийн хэмжээ батлах тухай” 10 дугаар тогтоолыг батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7205 дугаарт бүртгүүлсэн.

Мөн “Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэг”-ийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журмыг ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталж, үзлэгийг үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд 6 настны үзлэгт хамруулах ажлыг 2024 оны 4 дүгээр улиралд нийслэлийн хэмжээнд, 2025 оноос аймгуудад өргөжүүлсэн. Улсын хэмжээнд нэгдүгээр ангид суралцаж буй сурагчдыг зүрх, шүд, нүдний тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/413, А/151 тушаалын дагуу зохион байгуулж байгаа бөгөөд ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор журамлаж эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээт эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан санхүүжүүлж байна.

5.1.5. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний ЭМДС-ийн тусламж, үйлчилгээний зардалд эзлэх хувийг нэмэгдүүллээ.

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлсээр байна.

График 15. ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2025 онд зарцуулсан зардал (хувиар)



5.1.6. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр хорт хавдрын болон яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын тоо өсөж, төрөлжсөн төв эмнэлгийн төвлөрлийг саарууллаа.

Хорт хавдрын тусламж, үйлчилгээ болон яаралтай тусламжийн хувьд хэт их төвлөрсөн байдалтай байсан бол 2025 оны байдлаар хорт хавдрын хими, бай эмчилгээ хийдэг эрүүл мэндийн байгууллагын тоо 37 болж 2 дахин, мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлдэг байгууллагын тоо 2021 онд 5 байсан бол 2025 онд 41 болж 7 дахин, эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага Улаанбаатар хотод 33 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 18. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрөл саарсан байдал 2021-2025 он

№	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төрөл	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	Өсөлтийн хувь
1	Хорт хавдар хими, бай	13	16	30	37	37	184.6%
2	Хорт хавдар хөнгөвчлөх	26	37	41	46	46	76.9%
3	Хорт хавдар мэс засал	5	20	38	39	41	720.9%
4	Яаралтай тусламж	54	62	61	61	72	33.3%

5.1.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэдийн халааснаас төлөх хэмжээг буурууллаа.

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авч буй иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг хувиар тогтоох нь иргэд санхүүгийн хувьд ядууралд илүү өртдөг тул хамтын төлбөрийн бодлогод өөрчлөлт оруулж, хамтын төлбөрийн хэмжээг хувиар биш тогтмол мөнгөн дүнгээр төлөх хэлбэрт шилжүүлснээр өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд иргэдийн төлөх төлбөрийн хэмжээ буурсан. Тухайлбал, элэг шилжүүлэн суулгах мэс заслын төлбөрийн хэмжээ 113.6 сая, даатгуулагч хувиасаа 28.4 сая төгрөг төлдөг байсныг 5.0 сая төгрөг болгон бууруулснаар халааснаас төлөх төлбөрийн хэмжээ өмнөхөөс 5.7 дахин буурсан.

2025 онд нийтдээ 2.78 даатгуулагч тусламж, үйлчилгээ авсан бөгөөд үүнд 164.2 мянган буюу нийт даатгуулагчийн 5.9 хувь нь 2 саяаас дээш санхүүгийн хамгаалалт авсан байна. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь нийт хүн амдаа хүртээмжтэй, тусламж, үйлчилгээг худалдан авхад чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь хүнд өвчтэй даатгуулагчдад санхүүгийн хамгаалалтыг үзүүлж байгааг нотолж байна.

2022 онд даатгалын сангаас хамгийн өндөр санхүүгийн хамгаалалт авсан даатгуулагчийн мөнгөн дүн 126.9 сая төгрөг байсан бол 2025 онд 201.8 сая төгрөг болж, эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байна..

График 16. 2 сая төгрөгөөс дээш санхүүгийн хамгаалалт авсан иргэдийн тоо ба нийт тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид эзлэх хувь



5.2. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар:

5.2.1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталлаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14¹.4-т “Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.” гэж заасныг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн боловсруулж, УИХ-ын НББХ-ны 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн

ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 01 дүгээр тогтоолоор ЭМДҮЗ-ийн дүрмийг батлуулсан. Дүрэм батлагдсанаар Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй, хариуцлагатай болж, хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих эрх, үүрэг илүү өргөжин, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явц илүү сайжирч, ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг УИХ-аас томилогддог ажлын албаны ангилал, зэрэглэлтэй дүйцүүлэн тогтоох эрх зүйн үндэс бүрдсэн.

5.2.2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны дүрмийг шинэчлэн баталлаа.

ЭМДҮЗ-ийн шинэчилсэн дүрэмд нийцүүлэн Ажлын албаны дүрмийг 5 бүлэг, 20 хэсэг, 19 заалттайгаар шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан. Шинэчилсэн дүрэмд ЭМДҮЗ-ийн дэд дарга, ажлын албаны дарга, албаны гүйцэтгэх чиг үүрэг гэх мэт ажлын албаны удирдлага, зохион байгуулалтыг тодорхой тусгасан.

5.2.3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдааны дэгийг шинэчлэн баталлаа.

ЭМДҮЗ-ийн хуралдааны дэгийг ЭМДҮЗ-ийн шинэчилсэн дүрэмд нийцүүлэн 5 бүлэг, 37 хэсэг, 9 заалттайгаар шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2025.02.17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор, баталсан. Шинэчилсэн хуралдааны дэгд зохион байгуулалт, бэлтгэл үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийг албажуулах талаар тодорхой тусгасан.

5.2.4. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр УИХ-д санал, хүсэлтээ уламжлан ажиллалаа.

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлэгт ЭМДҮЗ-ийн гишүүн Ш.Зоригоо, Ж.Гэрэлмаа, Ажлын албаны дарга Ц.Сарантуяа нар оролцож, саналаа өгсөн.

Монгол Улсын Их Хурлын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 113 дугаар захирамжаар байгуулагдсан “ЭМД-ын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн ээлжит хурал 2025.04.25-ны өдөр Төрийн ордны Үндсэн хууль танхимд зохион байгуулагдсан. Тус хуралд ЭМДҮЗ-ийн гишүүд болон Ажлын албаны албан хаагчид оролцсон. Тус уулзалтанд зориулж “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, бодлогын шийдвэрүүд, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр танилцуулга бэлтгэж, ЭМДҮЗ-ийн гишүүн Н.Одонгуа танилцуулсан. Тус ажлын хэсгийн хуралдааны үед УИХ-ын гишүүдээс өгсөн үүрэг, чиглэлийн дагуу дараах мэдээллийг бэлтгэн гишүүдийн ажлын албанд тус тус хүргүүлсэн. Үүнд:

- ЭМД-ын сангаас зарцуулж буй тусламж, үйлчилгээний зардал нь хүн амын өвчлөлийн бүтэцтэй хэрхэн уялдаж байгаа талаар
- Эрүүл мэндийн даатгалын сангийн өнөөгийн байдал, орлого, зарлага, сангийн тэнцлийн талаар

- Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг хангахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай.

2025 оны 11.06-ны өдөр ЭМДҮЗ-өөс УИХ-ын ХХНББХ-ны гишүүдийг урьж уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны талаар болон ЭМДС-ын үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, зарчмын шинэчлэлт хийх, даатгалын системийг сайжруулах зэрэг асуудлаар санал солилцсон.

5.2.5. Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн байдал, бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын зөвлөхүүдтэй туршлага солилцлоо.

ЭМДҮЗ-ийн гишүүд, ажлын албаны албан хаагчдыг чадавхжуулах, мэдээ мэдээллээр хангах чиглэлээр гадаад, дотоодын сургалт, уулзалт бусад арга хэмжээнд хамруулах талаар Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Азийн хөгжлийн банкинд албан бичгээр санал хүргүүлсэний дагуу 2025.10.13-ны өдөр Дэлхийн банкны Эрүүл мэндийн зөвлөх Ц.Уранчимэгтэй гишүүдийн төлөөлөл, ажлын албаны дарга нар уулзалт зохион байгуулж, өөрсдийн санал хүсэлтийг танилцуулан, харилцан санал солилцсон.

Олон улсын зөвлөхүүд эрүүл мэндийн даатгалын сангийн менежментийг зөв хийхийн тулд бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтанд мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн холбоодыг түлхүү татан оролцуулах, нотолгоонд суурилан тогтвортой, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах, мэргэжлийн түвшинд хэлэлцэж, үр дүнг тогтмол үнэлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн ойлголтод хүрсэн.

5.3.ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:

5.3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын хэрэгжилтийн явцад хяналт, үнэлгээ хийсэн талаар:

5.3.1.1. Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийн талаар:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтын мэдээлэлд 2025 оны 1-12 сарын байдлаар төв орон нутгийн 313 эрүүл мэндийн байгууллагаас 10.8 сая тохиолдлын 1.4 их наяд төгрөгийн нэхэмжлэл ирүүлснийг хянасан байна.

А. Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл:

- ✓ төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 9,8 сая тохиолдлын 1,2 (85.4%) тэрбум төгрөг,
- ✓ хувийн хэвшлийн эмнэлэгт 0,9 сая тохиолдлын 181.0 (13.3%) тэрбум төгрөг,
- ✓ рашаан сувилалд 59.8 мянган тохиолдолд 17.1 (1.3) тэрбум төгрөгийг олгохоор тооцсон дүнтэй байна.

Б. Тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл нийт олгохоор тооцсон 1.4 наяд төгрөгийн:

- ✓ 57.5 хувь буюу 782.4 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд,

- ✓ 21.7 хувь буюу 294.9 тэрбум төгрөг амбулаторийн тусламж, үйлчилгээнд,
- ✓ 6.5 хувь буюу 88.5 тэрбум төгрөг өдрийн эмчилгээнд,
- ✓ бусад тусламж, үйлчилгээнд 0.0-3.9 хувь буюу 58,5 сая төгрөгөөс 53.2 тэрбум төгрөг зарцуулагдсан дүнтэй байна.

В. Тохиолдлын тоог авч үзвэл нийт 10.5 мянган тохиолдлын:

- ✓ 68.6 хувь буюу 7.2 сая тохиолдол нь амбулаторийн тусламж, үйлчилгээ
- ✓ 9.4 хувь буюу 993.8 мянган тохиолдол яаралтай тусламж, үйлчилгээ,
- ✓ 6.0 хувь буюу 629.8 мянган тохиолдлыг хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо эзэлж байна.

5.3.1.2. Нэхэмжлэлийн хяналтын хасагдлын талаар:

А. Нэхэмжлэлийн хяналтын шалгуур үзүүлэлт хангаагүй улмаас цахим хасагдлаар 34.8 тэрбум төгрөгийн хасалт, эмнэлзүйн нарийвчилсан хяналтаар 91.0 мянган тохиолдлын 26.7 тэрбум төгрөгийн хасалт, эх олонлогоор 25.7 мянган тохиолдолд 9 тэрбум төгрөгийн хасалт хийгдсэн байна.

Б. Нарийвчилсан хяналт болон эх олонлогоор хасагдсан нийт 35.7 тэрбум төгрөгийн хасалтийг эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл:

- ✓ хувь буюу 32.3 тэрбум төгрөгийг улсын эмнэлгүүдийн
- ✓ хувь буюу 3.4 тэрбум төгрөг хувийн эмнэлгүүдийн
- ✓ хувь буюу 12.9 сая төгрөгийг рашаан сувиллын нэхэмжлэлээс тус тус хасагдсан байна.

В. Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт болон эх олонлогийн хасалтаар хасагдсаныг тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл:

- ✓ нийт хасалтын 34.4 хувь буюу 24,3 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс,
- ✓ 10.3 хувь буюу 7.3 тэрбум төгрөг яаралтай тусламжаас хасагдсан дүнтэй байна.

5.3.2. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлснээс хойш буюу 2020 оноос хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, үнэ, хөнгөлөлттэй эмийн аргачлалыг шинэчилж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг батлан, хэрэгжүүлсэн.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын дагуу 156 өвчний үед хэрэглэх 161 эмэнд хамаарах 651 худалдааны нэршлийн эмэнд 30, 50, 70, 100 хувийн хөнгөлөлт үзүүлж байна. Үүнээс 0-19 хүртэлх насны хүүхдэд уналт, таталт өвчнийг эмчлэх 15 ерөнхий нэршлийн 77 эмэнд, “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийн 15 ерөнхий нэршлийн 26 эмэнд эрүүл мэндийн даатгалаас 100 хувийн хөнгөлөлт олгосон байна.

2025 онд 5.7 сая эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтийг санхүүжүүлсэн бөгөөд эдгээр жорын 1.0 хувийг 100 хувь, 70.0 хувийг 70 хувь, 26 хувийг 50 хувь, 4.0 хувийг 30 хувь тус тус хөнгөлөлт үзүүлсэн байна. Хөнгөлөлттэй эмийн жорын тохиолдлын тоо өмнөх оноос 959.3 мянгаар, санхүүжилт 38.8 тэрбумаар тус тус өссөн байна.

Хүснэгт 19. Эмийн үнийн хөнгөлөлт, хөнгөлөлтийн хувиар (сая.төг)

Хөнгөлөлтийн хувь	МД	2023 он		2024 он		2025 он	
		Тохиолдлын тоо	Олгосон санхүүжилт	Тохиолдлын т	Олгосон санхүүжилт	Тохиолдлын тоо	Олгосон санхүүжилт
А	Б	1	2	3	4	5	6
30%	1	984,889	10,460.2	512,940	3,775.1	763,520	5,860.2
50%	2	843,403	19,559.7	1,532,795	33,296.0	1,827,981	40,701.5
70%	3	1,809,036	56,859.9	2,556,188	94,185.3	2,933,959	110,093.1
100%	4	685749	8,804.9	680,488	3,300.9	201,271	1,108.7
Нийт дүн (мөр 1:4)	6	4,323,077	95,684.6	5,282,411	134,557.3	5,726,731.0	157,763.5

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 онд гэрээт эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтөд 192.6 сая ширхэг эмэнд 157.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2025 оны байдлаар нийт 784.6 мянган даатгуулагч хөнгөлөлттэй эм авсан буюу Монгол Улсын нийт хүн амын 22.1 хувьд нь хүрч байна. Мөн хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг авч байгаа даатгуулагчийн тоо 2020-2025 онд 1.9 дахин өссөн.

Хүснэгт 20. Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмж

Төрөл	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
А	Б	3	4	5	6	7
Монгол Улсын хүн амын тоо	1	3,357,542	3,409,939	3,457,548	3,504,741	3,544,835
Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчийн тоо	2	406,503	508,837	572,568	645,852	784,603
Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийн хувь, нийт хүн амд тооцсоноор	3	12.10%	14.90%	16.50%	18.40%	22.13%

Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо нь 2025 онд өмнөх онтой харьцуулахад 22 хувиар, санхүүжилт нь 17 хувиар тус тус өссөн байна. Нийт олгосон санхүүжилтийн 18.0 хувийг зүрх, судасны тогтолцоонд нөлөөлөх эм, 14 хувийг цусны эргэлтийн тогтолцоонд нөлөөлөх эм, 13.5 хувийг ходоод, гэдэсний замын эмгэгт хэрэглэх эм, 10.1 хувийг чихрийн шижингийн эм тус тус эзэлж байна.

Эмийн үнийн хөнгөлөлт авч байгаа нийт даатгуулагчийг шимтгэл төлөлтийн ангилалаар авч үзвэл 3 даатгуулагч тутмын 2 нь тэтгэврээс өөр мөнгөн тогтсол орлогогүй иргэн байна. Дээрх тоон мэдээллүүд нь даатгуулагчдад үзүүлэх эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох, даатгуулагчийг эм худалдан авахтай холбоотой үүсэх санхүүгийн дарамтыг нь бууруулах, эмийн

нэр төрлийг өргөжүүлэх болон үнийн уян хатан бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

5.3.3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний хэрэгжилт.


Анхан шатны тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгож, иргэн даатгуулагчийг илүү хамруулах зорилгоор санхүүжилтийг нэмэгдүүлэх, багцыг өргөжүүлэхэд анхаарч ажилласан. ЭМД-ын мэдээллийн санд бүртгэгдэж, тусламж үйлчилгээ авсан байдалд дүн шинжилгээ хийхэд анхан шатны тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо 2023 онд 2.0 сая байсан бол 2025 онд 2.1 сая, тохиолдолын тоо 8.7 сая байсан бол 2025 онд 10.7 сая болж хүртээмж нэмэгдсэн байна.

График 17. Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ авсан нийт хүний тоо 2022-2025 он



Гэвч нийт тусламж, үйлчилгээ авч буй иргэдийн тооноос харахад лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ авсан иргэд анхан шатны тусламж үйлчилгээ авсан иргэдээс өндөр байгаа нь анхан шатан дээр хаалга баригчийн үүргийг гүйцэтгэж чадахгүй байгааг илэрхийлж байна.

График 18. Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоо 2022-2025 он



Тусламж үйлчилгээний тохиолдолын тоонд эзлэх анхан шатны тусламж, үйлчилгээний тохиолдолын тоо нь жил ирэх тусам нэмэгдэж, 2025 онд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тооноос давсан байна.

5.4. Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 38 заалт, УИХ-ын 3 тогтоолын 7 заалт, ЭМДҮЗ-ийн 23 тогтоолын 74 заалт буюу нийт 27 хууль, тогтоомжийн 119 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан. Тогтоол шийдвэрийн биелэлтийн хувь 2025 онд 98.9 хувьтай байна.

Хүснэгт 21. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

№	Хяналтад авсан	Хууль, тогтоомжийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилт /хувиар/
1	ЭМД-ын тухай хууль	1	38	99.6
2	Монгол Улсын Их Хурлын тогтоол	3	7	100.0
3	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	23	74	98.0
Нийт		27	119	98.9

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, хийх журам”-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар үүрэг, чиглэл болгосон 38 заалтын хэрэгжилт 99.6 хувь, Улсын Их Хурлын 3 тогтоолын 7 заалтын хэрэгжилт 100.0 хувь, ЭМДҮЗ-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 23 тогтоолын 74 заалтын хэрэгжилт 98.0 хувь буюу нийт 27 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 119 заалтын хэрэгжилт 98.9 хувьтай байна.

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, баримт бичгийн улсын стандартын дагуу хариутай 28, нийт 135 албан бичиг, 21 өргөдөл, гомдол хүлээн авч, бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, иргэдэд 173 албан бичиг боловсруулан хариу хүргүүлсэн байна.

2025 онд ЭМДҮЗ-ийн батлагдсан төсөв 824.3 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулан, санхүүгийн өр төлбөр, авлагагүй ажилласан байна.

5.5. Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, аудитаар сангийн төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор нийт 76,995.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 175.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 76,820.1 сая төгрөгийн 7 зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.

5.5.1. Албан шаардлага 1139/АО170401 биелэлт:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021.05.11 өдрийн 07/1087 тоот дүгнэлтийг үндэслэн засварын ажлыг гэрээний дагуу гүйцэтгүүлсэн.

5.5.2. Албан шаардлага 954/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:

Агентлагийн даргын баталсан 2025/01 дүгээр удирдамжийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд, Эмийн жагсаалт шинэчлэн батлах тухай ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтэд тус тус дотоод аудит, хяналт-шинжилгээ хийж, дүнг агентлагийн удирдлагууд хэлэлцэж, холбогдох нэгжүүдэд зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж байна

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 2 зөвлөмж, 1 албан шаардлага ирүүлснийг биелэлтийг ханган ажиллаж, заасан хугацаанд нь Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

5.5.3. Аудитын зөвлөмжийн биелэлтийн талаар:

Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас ЭМДСангийн өр төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийг худалдан борлуулах ажлыг эрчимжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны А/06 дугаар тушаалаар байгуулж, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Капитал банкны 136.1 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус банкны эрх хүлээн авагч 15.0 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авсан, 74.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүлээн авсан 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөөс 12.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг борлуулан эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн, 32 аж ахуй нэгж, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулан 1.3 тэрбум төгрөгийн түрээсийн орлогыг санд төвлөрүүлээд байна.

Мөн банкны өр төлбөрт хураагдсан үл хөдлөх хөрөнгийг дахин дуудлага худалдаанд оруулж, худалдан борлуулах ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай болон Ерөнхий сайдын 2025 оны 70 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны 10 дугаар сарын байдлаар 74.0 хувийн хэрэгжилттэй, Үндэсний зөвлөлийн Ажлын албаны зөвлөмжийн биелэлт жилийн эцсийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна.

5.6. Сангийн яамнаас эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

Сангийн яамны дотоод аудитын нэгжээс Сангийн сайдын 2024 оны СХШХ-09 дугаартай удирдамжийн дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн.

5.6.1 Монгол улсын сангийн яам улсын ахлах байцаагчийн акт (Эрсдэлийн сангийн хөрөнгийг төвлөрүүлэх тухай 2024.11.01, 02/01-09)-ийн биелэлт.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, ЭМДҮЗ-н 2024 оны 1-р сарын 8-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай” 01 дугаар тогтоолын дагуу 2024 оны 12-р сарын 9 өдөр эрсдэлийн санд 53,562,600,000.0 төгрөгийг байршуулсан.

5.6.2 Монгол улсын сангийн яам улсын ахлах байцаагчийн албан шаардлага (Зөрчил арилгуулах тухай 2024.11.01, 02/01-09)-ын биелэлт:

Хуримтлагдсан өр төлбөрийг бууруулах зорилгоор 2025 онд эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээнд тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, төсөв тавьж архаг тусламж, үйлчилгээг тодорхой хувиар хязгаарласан, мөн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээ, диализ, хорт хавдар, яаралтай мэс заслын тусламж, үйлчилгээнээс бусад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээг зогсоож, анхан шатны зарим тусламж, үйлчилгээний төсвийг тодорхой хувиар бууруулах зэрэг хязгаарлалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр, өмнөх оны өглөгийг буурч, 202.6 тэрбум төгрөгийн өглөг үүссэн. 2025 онд дээрх хязгаарлалтын бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр жилийн эцэст олон тэрбум төгрөгийн өглөгө гарах нөхцөлийг арилгасан байна.

Түүнчлэн ЭМДҮЗ-н 2025 оны “төсвийн нарийвчилсан хуваарь батлах тухай” 01, 13, 15, 17 дугаар тогтоолоор төсвийн хуваарийг сар, улирал бүрээр баталж, хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна.

5.6.3 Монгол улсын сангийн яам улсын ахлах байцаагчийн албан шаардлага (Зөрчил арилгуулах тухай 2024.11.08, 02/01-09)-ын биелэлт:

ЭМДЕГ-ын даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/100 дугаар тушаалаар 11 дүгээр тогтоолын шинэчлэлд дэмжлэг үзүүлэх, иргэн даатгуулагчид үзүүлж буй хөнгөлөлттэй эмийн чанар, хүртээмж, санхүүгийн хамгаалалтын талаарх тооцоо, судалгаа хийх, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, ажлын хэсэгт эмийн мэргэжлийн мэргэшсэн холбоодын төлөөллүүдтэй оролцуулж, хамтран ажиллаж байна.

5.6.4 Сангийн яамны дотоод аудитын хорооны тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн биелэлт:

Сангийн яамны дотоод аудитын хорооны тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах 16 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, баталж, хэрэгжилтийг ханган, биелэлтийг улирал тутам Сангийн яаманд хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 93 хувийн гүйцэтгэлтэй байна.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХҮНИЙ НӨӨЦ, ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

6.1. Байгууллагын хүний нөөц:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулж, ЭМДҮЗ-ийн 2020 оны 17 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын бүтцийг баталсан.

Хүснэгт 22. ЭМДЕГ-ын хүний нөөцийн өөрчлөлт, 2022-2025 он

Шалгуур үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025 он
Орон тоо (нийт ажилтан)	170	191	193	196
Албан тушаалын шинэчилсэн тодорхойлолт (тоо)	-	28	-	-
Сул орон тоо нөхсөн (тоо)	6	7	1	

Албан тушаал шилжүүлэн болон сэлгэн ажилласан (тоо)	47	42	48	2
Хөдөлмөрийн гэрээ шинэчлэгдсэн ажилтан (тоо)	13	13	12	12

Засгийн газрын тогтоолын дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээг үндэслэн ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/04 дүгээр тушаалаар 178 албан хаагчийн цалинг шинэчлэн баталлаа.

Шинэчлэн тогтоосон цалинд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдэл 118 албан хаагчид 18-34 хувиар, төрийн алба хаасан хугацаанаас хамаарч 169 албан хаагчид 1-25 хувиар, ур чадварын нэмэгдэл 31 ажилтанд 25 хувиар, мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдэл 6 албан хаагчид 15 хувиар үндсэн цалингаас тус бүр нэмэгдлийг тооцон олгож байна. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, цалин нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай, үр дүнтэй бүтээлчээр ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор төрийн үйлчилгээний ангилалд ажиллаж байгаа 31 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцон олгож байна.

2020-2025 оны хугацаанд Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр 79, давхардсан тоогоор 139 буюу нийт 218 албан хаагчдад ахиулан олгуулсан байна.

Хүснэгт 23. ЭМДЕГ-ын хүний нөөцийн цалин, урамшуулал, тусламж

Шалгуур үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он	2024 оны өөрчлөлт хувиар	2025 оны өөрчлөлт хувиар
Үр дүнгийн урамшуулал авсан ажилтан (тоо)	156	187	183	19.87%	3.7%
Буцалтгүй тусламж авсан ажилтан (тоо)	36	32	26	-11.11%	371.8%
Буцалтгүй тусламжийн нийт мөнгөн дүн (сая ₮)	34.2	27.1	26.1	-20.82%	104%

6.2. Эрүүл мэндийн даатгалын нөхөн олголт:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад нөхөн төлүүлнэ.” гэж заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 онд 3,815.2 сая төгрөгийн зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 1.5 дахин өссөн байна.

Хүснэгт 24. Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал

Он	Гэм буруутай иргэдийн тоо	Нөхөн төлүүлсэн дүн /мян.төг/
2022	610	281,233.9
2023	1646	1,066,668.6
2024	3421	2,407,566.5
2025	5022	3,815,236.3
Нийт	10699	7,570,705.3

Даатгуулагчийн гомдлын мөрөөр 2025 онд ЭМДЕГ-аас 102 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтыг хийж, иргэн-даатгуулагчийн нэмэлт төлбөр төлсөн мэдээллийг баримт нотолгоонд тулгуурлан бодитой эсэхийг нягтлан шалгаж, тусламж, үйлчилгээ авах үедээ гэрээнд заагаагүй нэмэлт төлбөр авсан 6 иргэний төлбөрийн баримтыг үндэслэн 5,030,800 мянган төгрөгийг буцаан олгуулж, даатгуулагчдыг хохиролгүй болгосон.

Хүснэгт 25. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг)

Буцаан олголт	2022 он		2023 он		2024 он		2025 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Эрүүл мэндийн байгууллага нь эм тариа гаднаас авахуулсан	-	-	5	11,285.4			2	2,364.6
Гэрээнд тусгагдаагүй нэмэлт төлбөр авсан	12	13,996.4	3	2,323.3	6	455.0	6	5,030.8
Өөр байгууллагад оношилгоо, шинжилгээнд илгээсэн	-	-	3	1,996.2	-	-	-	-
Мессеж мэдээллийн дагуу газар дээрх хяналтаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаанд нь гаднаас авхуулсан эм тарианы мөнгийг буцаан олгуулсан байдал	-	-	9	1,078.9	-	-	-	-
Эрүүл мэндийн даатгалын санд нөхөн төлүүлсэн	-	-	-	-	-	-	5	18,081.9
Шийтгэл ноогдуулсан	-	-	-	-	-	-	8	16,000.0
Нийт	12	13,996.4	20	16,683.7	6	455.0	21	41,477.4

6.3. Эрүүл мэндийн даатгалын цахимжилт:

Эрүүл мэндийн даатгалын болон салбарын бодлого, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан цахим системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг тогтмол хийж, мэдээлэл солилцоо, нэхэмжлэлийн хяналт, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд даатгалын гэрээтэй 2417 байгууллага холбогдсон бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх, хяналт тавих зорилготой эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэн ажилласан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран төрийн мэдээлэл солилцооны ХУР системийн 17 сервис, дан системийн 1 сервисийн хөгжүүлэлт хийж, байгууллагын мэдээлэл шалгах боломжийг бүрдүүлсэн.

Цахим системийн тасралтгүй хөгжүүлэлтийг хангаж, бодлогын өөрчлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцүүлэн, лавлагаа болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээлэл хүлээн авах, нэхэмжлэлийн хяналтыг бүрэн цахимжуулах зорилгоор мэдээлэл солилцох болон баталгаажуулах, төр даах эм,

урьдчилан сэргийлэх, хорт хавдрын илрүүлэг зэрэг чиглэлээр нийт 62 сервисийг хөгжүүлсэн.

“Edaatgal” гар утасны аппликейшн болон хиймэл оюунд суурилсан чатбот системийг нэвтрүүлж, нийт 600 гаруй модульд шинэчлэл, сайжруулалт хийсэн.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн зэрэг нийт 301,5 мянган хүн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 44.0 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байна. **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан шимтгэлээ төлсөн даатгуулагчийн тоо өмнөх оноос 14.1 тэрбум төгрөгөөр өссөн сайн үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд цугларсан их өгөгдөл мэдээллийг боловсруулж хяналт хийх, шийдвэр гаргах процесст ашиглах зорилгоор дата боловсруулах хяналтын цахим системийг нэвтрүүлж, нийтдээ 18 тайлан судалгааны зорилгоор “**Tableau систем**”-ийг даатгалын байгууллагын хүрээнд нэвтрүүлэн эмийн борлуулалт болон даатгуулагчийн шимтгэлийн мэдээллийг аппликейшнд харах боломжийг бүрдүүлсэн. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн мэдээллийг нэгтгэн боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, өгөгдлийн чанар, бүрэн бүтэн байдлыг сайжруулсан.

Эрүүл мэндийн даатгалын цахим программыг санхүүгийн **Fiscus** програмтай холбож, даатгалын гэрээтэй аймаг, нийслэлийн 2417 эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн баазыг баяжуулж, 2025 онд гэрээ бүхий байгууллагуудын урьдчилгаа болон эцсийн олгохоор тооцсон санхүүжилттэй холбоотой нийт 62884 нэхэмжлэлийн мэдээллийг Фискус системд илгээсэн.


ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04, болон 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нийт 71 өөрчлөлт, 618 модуль хөгжүүлэлт хийгдэж, гэрээний мэдээллийг шинэчлэн, кодчлолын өөрчлөлтүүдийг нэвтрүүлэн даатгалын сангийн үйл ажиллагааны цахимжилт тасралтгүй, тогтмол үргэлжилсээр байна.

6.4. Сургалт, сурталчилгааны үр дүн:

Даатгуулагч-иргэдийг тогтмол мэдээллээр хангах чиглэлээр 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 976 контент бэлтгэн түгээсэн нь давхардсан тоогоор 8,436 мянга гаруй хүнд хүрч, 31,620 удаа хуваалцжээ.

Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 138,1 мянган хүн ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандаж, контент хуваалцсан байна.

График 19. Контент хуваалцсан тоо, 2022-2025 он



Сүүлийн 4 жилд давхардсан тоогоор 26,125.4 мянган хүн мэдээлэл авахаар ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандсан байна.

График 20. Бэлтгэсэн контентын тоо, 2023-2025 он





График 21. Контент хандалтын давхардсан тоо, 2022-2025 он



ЭМД-тай холбоотой мэдээ мэдээлэлд мониторинг хийж, цаг алдалгүй хариу арга хэмжээг авч түргэн шуурхай ажилласны үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр эрүүл мэндийн даатгалтай холбоотой 2439 мэдээ, мэдээлэл гаргасан байна.

График 22. ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт





График 23. Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал



ЭМДЕГ-т мэдээлэл авахаар хуулийн этгээд, иргэнээс хандсан асуудлыг авч үзэхэд санхүүжилттэй 27.2 хувь, даатгалын гэрээ байгуулах, сунгахтай 12.5 хувь, мэдээллийн технологи 9.6 хувь, нэхэмжлэлийн хяналтын асуудлаар 8.7 хувь, шимтгэл төлөлт 10.1 хувь, өргөдөл гомдол 0.4 хувийг тус тус эзэлж байна.

График 24. ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар:



6.5 Өргөдөл, гомдол шийдвэрлэлт:

2025 онд иргэд, байгууллагаас 15888 өргөдөл, гомдол ирсэнийг 100 хувь шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 26. Өргөдөл гомдол шийдвэрлэлт 2022-2025 он

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025 он
Хүлээн авсан өргөдөл, гомдол	15,215	113,712	1 03,012	15888
Шийдвэрлэсэн	15,193	113,598	102,432	15888
Шийдвэрлэлт (%)	98%	99.9%	99.8%	100%

Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 тусгай дугаарт жилийн эцсийн байдлаар нийт 107,770 даатгуулагч-иргэд хандсан байна. Тодруулбал, 83,226

холбогдсон дуудлага ирж, 12,892 даатгуулагч иргэн автомат хариулагчаас мэдээлэл авч, 6230 дуудлага руу эргэн холбогдож, 3665 иргэний бүртгэл, төр хариуцах иргэдийн мэдээллийг шивж оруулж, 1757 биеэр ирсэн иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, санал гомдлыг шийдвэрлэн ажилласан байна.

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаагаар 2025 онд Хэрэглэгчтэй харилцах төвд хандсан 10 иргэн тутмын 9 нь мэдээллээ чанартай авсан дүн гарсан.

Хүснэгт 26. Хэрэглэгчтэй харилцах төвийн дуудлагын тоо

Төрөл	МД	Хандалтын тоо			Өөрчлөлтийн хувь
		2023 он	2024 он	2025 он	
А	Б	1	2	3	$4=(3-2)/2$
1800-1363 лавлах утсанд ирсэн дуудлага	1	118,294	93,135	83,558	-10,3%
Шугам чөлөөгүй үед эргэн холбогдсон дуудлага	2	7,038	10,075	6,230	-38,1%
Автомат хариулагчаас авсан мэдээлэл	3	61,559	40,074	12,866	-67,9%
Хэрэглэгчтэй харилцах төвд биечлэн ирсэн иргэд	4	1,307	2,038	1,757	-13,8%
Нийт хандалт (мөр 1:4)	5	189,323	145,322	104,411	-28,2%

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн утсаар дамжуулан нийт 356 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч, бүрэн барагдуулан ажиллалаа.

Хүснэгт 27. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн утсаар гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тоо

Төрөл	МД	2023 он		2024 он		2025 он		Өөрчлөлтийн хувь
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	
А	Б	1	2	3	4	5	6	$7=(5-3)/3$
Гомдол	1	683	84%	495	81%	262	73.6%	-47%
Хүсэлт	2	32	3.9%	41	6.7%	50	14%	22%
Санал	3	97	12%	68	11.15%	36	10.1%	-47%
Шүүмжлэл	4	1	0.1%	7	1.15%	7	2%	0%
Талархал	5	-	-	-	-	1	0.3%	0%
Нийт (мөр 1:5)	6	813	100%	611	100%	356	100%	-41.7%

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Даатгалын сангийн орлого 2025 оны төсвийн тухай хуулиар 2 их наяд 464.3 тэрбум төгрөг батлагдаж, 2 их наяд 299.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, зарцуулалт 2 их наяд 246.2 тэрбум төгрөг болж, цэвэр ашиг нэмэх үзүүлэлттэй гарсан.

2. Засгийн газрын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2024 онд 8.4 хувь байсан бол 2025 онд 8.5 хувь болж 0.1 хувиар өссөн ч Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.5 пунктээр доогуур байгаа тул Засгийн газрын нийт зардалд эзлэх эрүүл мэндийн салбарын зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна;

3. 2025 онд эрүүл мэндийн улсын зардалд эзлэх ЭМД-ын сангийн зардлын хувь 82.3, эрүүл мэндийн улсын зардалд эзлэх улсын төсвийн шилжүүлгийн хэмжээ 17.7 хувьтай байна;

4. Эрүүл мэндийн даатгалд нийт хүн амын 94.0 хувийг хамруулсан нь “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгасан 2030 оны зорилтот түвшинд хүрээд байна.

5. Анхан шатны тусламж, үйлчилгээ авч буй иргэдийн тоо 2023 онд 2 сая байсан бол 2025 онд 2.1 сая, тохиолдолын тоо 8.7 сая байсан бол 10.7 сая болж хүртээмж нэмэгдсээр байна.

6. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг илүү өргөжүүлж, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудыг нэмэгдүүлэх, хамтын төлбөрөөс чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүд авсанаар 2025 онд нийт тусламж, үйлчилгээний зардлын хамгийн өндөр буюу 90 хувийг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулсан байна.

7. Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогын хүрээнд хамтын төлбөрөөс чөлөөлж санхүүгийн эрсдэлийг хуваалцдаг болсон. Хамтын төлбөрийн чөлөөлөлтөд 2022 онд 47.1 тэрбум, төгрөгийг зарцуулсан бол 2025 онд 80.5 тэрбум болж нэмэгдсэн байна.

8. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн зэрэг нийт 301,5 мянган хүн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 44.0 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байна. **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан шимтгэлээ төлсөн даатгуулагчийн тоо өмнөх оноос 14.1 тэрбум төгрөгөөр өссөн сайн үзүүлэлттэй байна.

Цаашид анхаарах асуудал, санал

1. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлдөг даатгуулагчдийн шимтгэлийн орлого сангийн орлогын 25.6 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 76.2 хувийг эзэлж байгаа тул төрөөс эрүүл мэндийн даатгалыг хариуцах иргэдийн шимтгэлийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх;

2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг татвар төлж буй орлогын хэмжээтэй уялдуулан тогтоох замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх;

3. Анхан шатны тусламж үйлчилгээний ашиглалтыг 70 хувьд хүргэх замаар лавлагаа шатлалын шаардлагагүй тоо хэмжээг бууруулж, анхан шатны хаалга баригчийн тогтолцоог бэхжүүлэх;

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналтын тогтолцооны реформ хийх, зардлыг хянах, судлах нөхцөл бүрдүүлэх, бүрэн цахимжуулах;

5. Эрүүл мэндийн даатгалын их өгөгдөлийн сан үүсгэх, ашиглах үйл явцын зураглалыг боловсронгуй болгох;

6. Эмийн худалдан авалт, хөнгөлөлтийг шинэчлэх.



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

**2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН
СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2026 он**

АГУУЛГА

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. ЭМДҮЗ-ийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
- 2.2. ЭМДЕГ-ын чиг үүрэг, бүтэц
- 2.3. ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа
- 2.4. ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэр

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 3.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ
- 3.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого
- 3.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага
- 3.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл
- 3.5. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээ авсан зардлын харьцаа
- 3.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал

ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- 4.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар
- 4.2. ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, онцлох шийдвэрүүд
- 4.3. ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар
- 4.4. Хууль тогтоомжийн биелэлтийн талаар
- 4.5. Бусад

ТАВ. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

- 5.1. Сангийн яамнаас эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар
- 5.2. Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

- 6.1. Эрүүл мэндийн даатгалын нөхөн олголт
- 6.2. Эрүүл мэндийн даатгалын цахимжилт
- 6.3. Сургалт, сурталчилгаа

ДОЛОО. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХАРЬЦУУЛАЛТ

- 7.1. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ
- 7.2. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ
- 7.3. Эмийн үнийн хөнгөлөлт
- 7.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

НАЙМ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
НББСШУ	Нийгмийн Бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОШ	Оношилгоо, шинжилгээ

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1.ЭМДҮЗ-ийн бүтэц	5
схем 2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц	6

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
График 2. ЭМДС-ийн орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар) .	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
График 3. ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэл, (тэрбум төг), 2018-2025 он,	14
График 4. ЭМДС-ын орлогыг датгуулагчийн нэр төрлөөр болон даатгуулагчид ЭМДС-аас зарцуулсан зардлын эзлэх хувь 2023-2025 он.	ERROR! BOOKMARK NOT DEFINED.5
График 5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь, ЭМБ-ын төрлөөр 2025 он	17
График 6. ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2025 онд зарцуулсан зардал	ERROR! BOOKMARK NOT DEFINED.21
График 7. 2 сая төгрөгнөөс дээш санхүүгийн хамгаалалт авсан иргэдийн тоо ба нийт тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид эзлэх хувь 2022-2025 он	ERROR! BOOKMARK NOT DEFINED.22
График 8. Контент хуваалцсан 2022-2025 он.....	29
График 9. Бэлтгэсэн контентын тоо 2023-2025.....	29
График 10. Контент хандалтын давхардсан тоо 2022-2025 он	ERROR! BOOKMARK NOT DEFINED.30
График 11. ЭМДЕГ-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт	30
График 12. Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал	30
<u>График 13. ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар 2024-2025 он.....</u>	<u>31</u>
График 14. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдолын тоо	33

График 15. Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2025 он, сая төгрөгөөр	37
График 16. Эмийн үнийн хөнгөлөлт насны ангилалаар 2022-2025.....	37

ХАВСРАЛТ

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн хуралдааны ирц, 2024 он

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хүний нөөцийн орон тоо	6
Хүснэгт 2. ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2024 он.....	7
Хүснэгт 3. ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр.....	7
Хүснэгт 4. ЭМДҮЗ-ийн 2024 онд баталсан тогтоолууд.....	8
Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2019-2024 он	9
Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын хамралт,даатгуулагчийн төрлөөр,.....	10
Хүснэгт 7. ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг	12
Хүснэгт 8. ЭМДС-ийн зарлагын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг.....	13
Хүснэгт 9. ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 2023-2024 оны үлдэгдэл, сая.төгрөг	14
Хүснэгт 10.ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2023-2024 онд.....	16
Хүснэгт 11. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын тоо	21
Хүснэгт 12. Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал 2022-2024 он /тэрбум төгрөгөөр/	21
Хүснэгт 13 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт.....	24
Хүснэгт 14. Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас олгох өглөг, сая төгрөг, 2021-2024 он	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
Хүснэгт 15. Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал, 2022-2024 он	27
Хүснэгт 16. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг).....	27
Хүснэгт 17. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2024 он.....	31
Хүснэгт 18. ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2024 он	34
Хүснэгт 19. ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр.....	35
Хүснэгт 20. СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр.....	36
Хүснэгт 21. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2024 он, сая төгрөгөөр.....	36
Хүснэгт 22. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо,	38
Хүснэгт 23. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт,	38

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “ЭМДҮЗ” гэх/-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланд Хууль зүйн яамнаас боловсруулсан 2011 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 55 дугаар “Аргачлал батлах тухай ” тушаалын дагуу үнэлгээ хийсэн болно.

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэх бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа
- Салбарын эрх зүйн орчин
- Дотоод үйл ажиллагаа

ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. ЭМДҮЗ-ийн чиг үүрэг, бүтэц: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14¹.1-т “Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.”, 14¹.2-т “Үндэсний зөвлөл нь ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.” гэж тус тус заасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т зааснаар эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрддэг хуулийн зохицуулалттай.

ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

ЭМДҮЗ нь бүтцийн хувьд Засгийн газрыг төлөөлсөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлсөн 3 гишүүн, орон тооны бус нийт 9 гишүүнтэй, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай. Ажлын алба нь ЭМДҮЗ-ийн 2025 оны 07 дугаар тогтоолоор баталсан

бүтэц, орон тооны дагуу 12 орон тоотойгоос 9 орон тоотойгоор 2025 онд үйл ажиллагаа явуулж ирлээ.

Схем 1.ЭМДҮЗ-ийн бүтэц



Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14^{1.2} дахь хэсэгт зааснаар Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийж таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг.

Улсын Их Хурлын 2017 оны 40 дүгээр тогтоолоор томилогдсон ЭМДҮЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдыг, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр Б.Алтанхуяг, Т.Баясгалан, С.Эрдэнэбат, ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр Ж.Гэрэлмаа, Ш.Зориггоо, Н.Одонгуа нарыг тус тус томилсон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, ЭМДҮЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ НББХ-нд гаргасан тул Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Б.Рагчааг даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр шинэчлэн томилсон.

2.2.ЭМДЕГ-ын чиг үүрэг, бүтэц: Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан бөгөөд эрүүл мэндийн


даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж, хяналт тавих, даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн зардлыг санхүүжүүлэх, хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд олгох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, иргэд, даатгуулагчид Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулан таниулах замаар хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хэрэгжилтийг ханган ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 155-аар баталсан.

байхаар шинэчлэн тогтоосон.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дүрмийг, 2020 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан байна.

Схем 2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц



Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бүтцийн хувьд 5 газар, 7 хэлтэстэй, 2021 оноос 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг өргөжүүлэн “Эрүүл мэндийн даатгалын хэлтэс” байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хүнийн нөөцийн орон тоо

Он	Орон тоо баталсан шийдвэр	Батлагдсан орон тоо	2025 онд ажилласан орон тоо	Сургалтын тоо		Цалин шинэчилсэн албан
				Дотоод	Гадаад	

						хаагчийн тоо
ЭМДҮЗ	УИХ-ын НББСШУБХ- ны 2018 оны 18 дугаар тогтоол	12	9	3	0	9
ЭМДЕГ	Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоол	155	178 (Төв аппаратын болон орон нутгийн нийт орон тоо)	42	5	178

2.3.ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа: ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.10-т “Үндэсний зөвлөл нь улиралд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах

Он	Хуралдааны тоо	Хэлэлцсэн асуудал	Баталсан тогтоолын тоо	ЗХХАУБ-д бүртгэгдсэн тогтоолын тоо	Гишүүдийн дундаж ирц
2022	12	24	18	6	77.7%
2023	6	15	12	6	80.3%
2024	8	25	16	4	83.2%
2025	11	35	18	3	86.3
	26	64	46	14	83.2%

бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна.” гэж зааснаар 2025 онд 10 удаагийн ээлжит, 1 удаагийн ээлжит бус хуралдаан танхимаар зохион байгуулж, хуралдааны ирц дунджаар 86.3 хувь байна.

Хүснэгт 2. ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2025 он

ЭМДҮЗ нь 2025 онд 11 удаа хуралдаж, 35 асуудал хэлэлцэж, 18 тогтоол батлан гаргасан байна.

Хүснэгт 3. ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр

№	Хуралдсан огноо	Гишүүдийн ирц хувь	Хэлэлцсэн асуудлын тоо	Хуралдаанаар баталсан шийдвэрийн тоо
1	2025.01.02	77.7	5	2
2	2025.01.14	88.8	3	3
3	2025.03.17	77.7	3	3
4	2025.04.25	77.7	6	4
5	2025.07.24	100	2	2
6	2025.08.14	88.8	4	3

7	2025.10.27	88.8	2	1
8	2025.11.03	88.8	3	-
9	2025.11.28	88.8	3	-
10	2025.12.22	77	3	1
11	2025.12.30	80	1	1
Нийт			35	18/3

2.4.ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэр: ЭМДҮЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ЭМДҮЗ нь 2025 онд 10 удаагийн ээлжит, 1 удаагийн ээлжит бус хуралдаанаар 15 тогтоол, өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 3 тогтоол, нийт 18 тогтоол баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 3 актыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд шинээр бүртгүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Одоогийн байдлаар ЭМДҮЗ-ийн 2017-2025 оны 30 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хүснэгт 4. ЭМДҮЗ-ийн 2025 онд баталсан тогтоолууд

д/д	Тогтоолын огноо	№	Батлагдсан тогтоол
Нэг. ЭМДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн баталсан тогтоолууд			
1	2025.01.02	01	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай
2	2025.01.02	02	Өгөгдлийн санг төвлөрүүлэх тухай
3	2025.01.14	03	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай (анхан шат)
4	2025.01.14	04	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай (лавлагаа шат)
5	2025.01.14	05	Төлбөрийн хэмжээ, журам шинэчлэн батлах тухай” (урьдчилан сэргийлэх)
6	2025.03.17	09	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай
7	2025.03.17	10	Журам, төлбөрийн хэмжээ батлах тухай
8	2025.03.17	11	Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
9	2025.04.25	12	“Up to date” олон улсын эмнэлзүйн удирдамжийг үргэлжлүүлэн ашиглах тухай
10	2025.08.14	13	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай
11	2025.08.14	14	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам батлах тухай

12	2025.11.03	15	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай
13	2025.12.22	16	Тогтоол хүчингүй болгох тухай (2025 оны 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон)
14	2025.12.22	17	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай
15	2025.12.30	18	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн нарийвчилсан хуваарийг батлах тухай
Хоёр. Дотоод үйл ажиллагаатай холбоотой тогтоол			
16	2025.02.17	06	ЭМДҮЗ-ийн хуралдааны дэг шинэчлэн батлах тухай
17	2025.02.17	07	Ажлын албаны орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл тогтоох тухай
18	2025.02.17	08	Ажлын албаны дүрэм шинэчлэн батлах тухай

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон төрөөс эрүүл мэндийн даатгалын талаар баримтлах бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн орлого, зарлагын тэнцлийг хангах, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

3.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно” гэж заасан байдаг.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолтой уялдуулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан даатгуулагчийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар буюу 15840 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4 хувиар буюу 31680 төгрөгөөр тогтоож, 2025 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажилласан.

Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2019-2025 он

№	Даатгуулагчийн төрөл	Шимтгэлийн 2020, 2021,	Шимтгэлийн 2023 оны хэмжээ	Шимтгэлийн 2024 оны хэмжээ	Шимтгэлийн 2025 оны Хэмжээ
---	----------------------	---------------------------	----------------------------------	----------------------------------	----------------------------------

		2022 оны хэмжээ			(4-12 сар)
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ		420,000 төгрөг	550,000 төгрөг	660,000 төгрөг	792,000 төгрөг
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь			
2	0-18 насны хүүхэд				
3	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	4200 төгрөг (ХХДХ-ний 1%)	5500 төгрөг (ХХДХ-ний 1%)	6600 төгрөг (ХХДХ-ний 1%)	15840 төгрөг (ХХДХ-ний 2%)
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн	4200 төгрөг (ХХДХ-ний 1%)	5500 төгрөг (ХХДХ-ний 1%)	6600 төгрөг (ХХДХ-ний 1%)	15840 төгрөг (ХХДХ-ний 2%)
5	Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн	8400 төгрөг (ХХДХ-ий 2%)	11000 төгрөг (ХХДХ-ий 2%)	13200 төгрөг (ХХДХ-ий 2%)	15840 төгрөг (ХХДХ-ний 2%)
6	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	8400 төгрөг (ХХДХ-ий 2%)	11000 төгрөг (ХХДХ-ий 2%)	13200 төгрөг (ХХДХ-ий 2%)	31680 төгрөг (ХХДХ-ний 4%)

2025 онд эрүүл мэндийн даатгалд 3,283.5 мянган даатгуулагч хамрагдаж, нийт хамрагдалт 94.0 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагч 793.5 мянга, малчин 37.3 мянга, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 95.5 мянга, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч 54.5 мянга, эрүүл мэндийн даатгалыг нь төрөөс хариуцдаг иргэн 2,302.1 мянга, ял эдэлж буй ялтан 4.7 мянга, гадаадын иргэн 0.9 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын хамралт, даатгуулагчийн төрлөөр, 2022-2025 он

Төрөл	МД	2023 он	2024 он	2025 он	2025/2024 Харьцуулалт	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4=3-2	5=4/2
1	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.2 дахь хэсэгт заасан ажилтан	788,986	770,923	793,592	22,669	3%
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;	145,867	117,814	95,051	-22,763	-19%
3	Малчин	57,117	51,187	37,387	-13,800	-27%
4	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	667	1,306	854	-452	-35%
5	0-18 насны хүүхэд	1,329,131	1,353,649	1,371,550	17,901	1%
6	Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	538,558	554,674	572,152	17,478	3%
7	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	263,645	274,849	272,497	-2,352	-1%
8	Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	86,357	97,922	75,838	-22,084	-23%
9	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	18,815	42,518	54,507	11,989	28%
10	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	6,021	5,208	5,407	199	4%

11	Ял эдэлж байгаа ялтан	5,055	4,908	4,741	-167	-3%
	Нийт даатгуулагчийн тоо (Мөр 1:11)	3,240,219	3,274,958	3,283,576	8,618	0.3%

Тайлант онд сүүлийн 3 жилийн статистик судалгаанд үндэслэн улсын хэмжээнд хамрагдвал зохих малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан суралцагч тус бүрээр эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталж, төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.4 дэх заалтыг хэрэгжүүлэх, шимтгэлийн орлогыг цуглуулж баталгаажуулах, төвлөрүүлэх, уг хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэх, тайлагнах ажлыг гүйцэтгэх харилцааг зохицуулах зорилгоор НДЕГ болон ЭМДЕГ хоорондын 2025 оны НДЕГ09//25 ЭМДЕГ25/27 тоот дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

Эрүүл мэндийн даатгалд 2025 онд хамрагдагсдын тоог өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хамралт 22.6 мянгаар нэмэгдсэн бол өөрөө төлдөг даатгуулагчид буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийн хамралт 22.7 мянгаар, малчны хамралт 13.8 мянгаар тус тус буурч, төр шимтгэлийг нь хариуцдаг даатгуулагч (0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/-ийн хамралтын тоо өмнөх оноос нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын ойлголт, ач холбогдлыг сурталчлан таниулах нээлттэй өдөрлөг, сургалт сурталчилгааны ажлын үр дүнд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан их дээд сургууль болон мэргэжлийн сургалтын төвийн оюутны тоо өмнөх оноос 11.9 мянган даатгуулагчаар нэмэгдэж, хамралтын хувь 28 хувиар өссөн, аж ахуйн нэгж байгууллагын ажилтны хамрагдалт өмнөх оныхоос 22.6 мянган даатгуулагчаар нэмэгдэж, хамралт 3 хувиар өссөн эерэг үр дүнтэй байна.

График 1. Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр



Нийгмийн даатгалын тухай ерөнхий хууль 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой "Шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэд"-ийн орлогыг эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төвлөрүүлж эхэлсэн бөгөөд энэхүү орлого төвлөрүүлэлтийн үйл ажиллагааг И-монголиа, И-баримт системийг ашиглан бүрэн цахимжуулж, харин цахим хэлбэрээр төлөх боломжгүй иргэдийн асуудлыг арилжааны банкаар дамжуулан төлүүлсэн. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчид нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай үедээ эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлдөг буруу зан үйл, хандлагаас шалтгаалан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдын хамралт өмнөх оноос буурсан байна.

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2,464.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2025 оны 01, 13, 15 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарь болон хуваарийн өөрчлөлтийг тус тус баталж, хэрэгжилтийг хангуулсан.

Орлогын гүйцэтгэл 2.304.1 тэрбум төгрөг, үүнээс ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 977.2 тэрбум төгрөг, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 352.2 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 921.6 тэрбум төгрөг, бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 44.1 тэрбум төгрөг, бусад орлогоос 4.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төсвийн гүйцэтгэл 93.3 хувь байна.


Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан Азийн хөгжлийн банкнаас нэмэлт санхүүжилт 4.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2025 он, мян.төгрөг

№	Төсвийн үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	2025 он		
					Төсөв	Гүйцэтгэл	Хувь
САНГИЙН ОРЛОГО		1,219,075.1	1,563,809.7	1,921,743.4	2,464,319.5	2,299,523.0	93.3%
1	Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	487,150.0	616,566.5	812,662.2	1,140,709.0	977,214.9	85.7%
2	Төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	163,708.7	228,117.4	324,113.0	352,203.1	352,203.1	100.0%
3	Төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	540,429.9	687,445.3	746,804.8	921,575.9	921,575.9	100.0%
4	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	25,171.1	29,391.7	34,199.4	49,831.5	44,146.7	88.6%
5	Бусад орлого	2,615.4	2,288.8	3,964.0	0.0	4,382.4	
НЭМЭЛТ ЭХ ҮҮСВЭР		557,679.4	63,910.5	109,485.7		4,593.0	
6	Нэмэлт санхүүжилт	295,335.1	20,000.0	104,082.9		4,593.0	
7	Дансны үлдэгдлээс санхүүжих	262,344.3	43,910.5	5,402.8			
НИЙТ САНХҮҮЖИЛТ		1,776,754.5	1,627,720.2	2,031,229.1	2,464,319.5	2,304,116.0	

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрийн эзлэх хувийг авч үзвэл 42.5 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 40.1 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 15.3 хувийг төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, 1.9 хувийг бусад орлого тус тус эзэлж байна.

График 2. ЭМДС-ийн 2021-2025 оны орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)



3.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар сангийн зарлагыг 2,242.4 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 2,246.2 тэрбум төгрөгийг олгосон байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 2,061,9 тэрбум төгрөг буюу сангийн зарлагын 91.8 хувийг, эмийн үнийн хөнгөлөлтөд 171.1 тэрбум төгрөг буюу сангийн зарлагын 7.6 хувийг, үйл ажиллаганы зардалд 13.2 тэрбум төгрөг буюу сангийн зарлагын 0.6 хувийг, бусад буюу илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 17.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 8. ЭМДС-ийн зарлагын гүйцэтгэл, 2021-2025 он, мян.төгрөг

№	Төсвийн үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	2025 он	
					Төсөв	Олгосон гүйцэтгэл
	ЗАРЛАГА	1,877,320.4	1,785,446.0	2,129,752.8	2,242,447.3	2,246,230.8
1	Тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,603,425.7	1,635,339.8	1,923,313.5	1,740,532.2	1,745,125.1
2	Эмийн үнийн хөнгөлөлт	80,758.1	99,506.5	137,801.6	171,086.6	171,086.6
3	Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.0	-	-	-	-
4	Үйл ажиллагааны урсгал зардал	13,259.5	10,285.8	15,049.5	13,989.9	13,163.1
5	Эрсдэлийн сан	40,000.0	40,000.0	53,562.6	-	-
6	Бусад	348.5	313.9	25.6		17.4
7	ӨМНӨХ ОНЫ ӨГЛӨГ	264,665.0	60,595.9	218,321.7	316,838.6	316,838.6


8	НИЙТ ЗАРЛАГА	2,141,985.4	1,846,041.9	2,348,074.5	2,242,447.3	2,246,230.8
---	--------------	-------------	-------------	-------------	-------------	-------------

3.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл:

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага жил бүр тогтмол өсөж ирсэн ба жилийн дундаж өсөлт 19 хувь байсан бол 2021 оноос эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлтийн хүрээнд улсын төсвөөс олгодог байсан төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-д нэгтгэн нэг эх үүсвэрээс санхүүжүүлдэг болсноор 2020 онтой харьцуулахад ЭМДС-ийн 2025 оны орлого 4.6 дахин, зарлага 4.5 дахин нэмэгдсэн бол 2025 онд ЭМДС-ийн орлого 2,299.5 тэрбум, зарлага 2,246.2 тэрбум байгаа нь өмнөх оноос орлого 377.8 тэрбум төгрөгөөр, зарлага 116.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2025 оны ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолын хүрээнд сангийн тэнцлийг хангах, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тусламж, үйлчилгээнд эрэмбэ тогтоож өөрчлөлтийг хэрэгжүүлсэн. Үүнд олон улсад ашигладаг хатуу хязгаар тогтоох аргыг архаг өвчний тусламж, үйлчилгээнд, цочмог өвчний үед хязгаарлалтгүй, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээнд зөөлөн хязгаар буюу тодорхой түвшинд хүрээд тарифыг 20 хувь бууруулах зохицуулалтыг тусгаж хэрэгжүүлсэн.

График 1. ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэл, (тэрбум төг), 2018-2025 он



Тайлант оны жилийн эцэст ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 155.9 тэрбум төгрөгөөс 217.1 тэрбум төгрөг болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 2024-2025 оны үлдэгдэл, сая.төгрөг

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31	Зөрүү
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	155.9	217.1	61.3
ЭМДСан 100900091001	0.6	1.8	1.2
Төрийн сангийн харилцах данс	90.9	167.5	76.6

Арилжааны банк дахь харилцах данс	54.7	38.1	-16.6
Нэмэлт санхүүжилтийн харилцах	9.6	9.6	-

3.5. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээ авсан зардлын харьцаа:

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан үзэхэд:

- Цалин түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь нийт даатгуулагчийн 24.2 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 71.1 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 14.6 хувийг эзэлж байна.
- Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 70.1 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 25.6 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 76.2 хувийг эзэлж байна.
- Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагч нь нийт даатгуулагчийн 5.7 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 3.2 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 9.8 хувийг эзэлж байна.

График 4 Даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн орлого, зардлын эзлэх хувь



2025 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын 76.2 хувь нь төр шимтгэлийг нь хариуцан төлдөг даатгуулагч, 14.1 хувь нь цалин, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа даатгуулагч, 9.8 хувь нь шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд тус тус зарцуулагдсан байна.

Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтан хамаардаг бөгөөд нийт 2.3 сая гаруй даатгуулагчийн шимтгэлийг төрөөс хариуцдаг. Эдгээр иргэд нь нийт шимтгэлийн орлогын 25.6

хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 76.2 хувийг эзэлж байгаа нь зарлага нь орлогоос 2.9 дахин их байна.

3.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал:


2025 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд олгосон санхүүжилтийг тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд 1,360.4 тэрбум (65.7%) төгрөг, анхан шатны тусламж, үйлчилгээнд 513.7 тэрбум (24.8%) төгрөг, урьдчилсан сэргийлэх үзлэгт 25.3 тэрбум (1.2%) төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 171.1 тэрбум (8.3%) төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 10. ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2024-2025 онд олгосон санхүүжилт, ЭМБ-ын төрлөөр

Тусламж, үйлчилгээний төрөл	2024 он			2025 он		
	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хувиар	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хувиар
Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ	11,051,263	1,453,503.3	67.9%	10,583,840	1,360,385.8	65.7%
Анхан шатны тусламж, үйлчилгээ	2,097,303	487,446.1	22.8%	1,663,982	513,680.0	24.8%
Урьдчилсан сэргийлэх үзлэг	219,206	31,626.3	1.5%	152,703	25,363.4	1.2%
Эмийн үнийн хөнгөлөлт	5,269,352	169,454.1	7.9%	4,163,242	171,086.6	8.3%
Нийт	18,637,124	2,142,029.80	100.0%	16,563,767	2,070,515.80	100.0%

Нийт санхүүжилтийн 65.7 хувийг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтэд зарцуулж байгаа бол анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт 24.8 хувийг эзэлж байна.

График 5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь, ЭМБ-ын төрлөөр, 2025 он



ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

4.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороог байгууллаа.

ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.12 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулсан нь хараат бус, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах бодит нөхцөлийг бүрдүүлсэн. Техникийн хороо нь:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, чанарын хяналт болон эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, чанарын хяналтын асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач 3;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ санхүүгийн хяналтын асуудлаар мэргэшсэн санхүүгийн шинжээч, судлаач 2;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөл 2;
- Даатгуулагчийн эрх ашгийг төлөөлсөн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл 2 гишүүнээс тус тус бүрддэг.

Мэргэжлийн хувьд хүний их эмч 3, эрүүл мэндийн эдийн засагч 2, эдийн засагч 2, санхүүгийн менежмент 1, хэрэглээний статистикч 1, профессор цолтой 1, дэд профессор цолтой 3, доктор цолтой 4, докторант 1, магистр цолтой 9, гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан 3 гишүүн байна.

2025 онд Техникийн хороо ЭМДҮЗ-ийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2025 оны 03, 04 дүгээр тогтоол, Урьдчилан сэргийлэх, хорт хавдарын эрт илрүүлэгтэй холбоотой 2025 оны 05, 10 дугаар тогтоолуудыг батлахтай холбоотойгоор ажиллаж 226 хуудас бүхий 14 дүгнэлт, 38 зөвлөмж ирүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дүрмийг шинэчлэн баталлаа.

ЭМД-ын тухай хуулийн 141.5-т “Үндэсний зөвлөл ажлын албатай байна”, НББХ-ны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан ЭМДҮЗ-ийн дүрмийн 3.2.4-т “Үндэсний зөвлөлийн ажлын албаны дүрмийг батлана;” гэж заасныг үндэслэн Ажлын албаны дүрмийг 5 бүлэг, 20 хэсэг, 19 заалттайгаар боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2025.02.17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Шинэчилсэн дүрэмд ажлын албаны удирдлага, зохион байгуулалт, ЭМДҮЗ-ийн дэд дарга, ажлын албаны дарга, албаны гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож тусгасан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдааны дэгийг шинэчлэн баталлаа.

ЭМДҮЗ-ийн дүрмийн 2.1-д “Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаан болон цахим хуралдааны дэгийг Үндэсний зөвлөл тогтооно” гэж тус тус заасны дагуу хуралдааны дэгийг 5 бүлэг, 37 хэсэг, 9 заалттайгаар шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2025.02.17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан.

Шинэчилсэн хуралдааны дэгд зохион байгуулалт, бэлтгэл үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийг албажуулах талаар тодорхой тусгасан.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр УИХ-д санал, хүсэлтээ уламжлан ажиллалаа.

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлэгт ЭМДҮЗ-ийн гишүүн Ш.Зоригоо, Ж.Гэрэлмаа, Ажлын албаны дарга Ц.Сарантуяа нар оролцож, саналаа өгсөн.

Монгол Улсын Их Хурлын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 113 дугаар захирамжаар байгуулагдсан “ЭМД-ын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн ээлжит хурал 2025.04.25-ны өдөр Төрийн ордны Үндсэн хууль танхимд зохион байгуулагдсан. Тус хуралд ЭМДҮЗ-ийн гишүүд болон Ажлын албаны албан хаагчид оролцсон. Тус уулзалтанд зориулж “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, бодлогын шийдвэрүүд, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр танилцуулга бэлтгэж, ЭМДҮЗ-ийн гишүүн Н.Одонгуа танилцуулсан. Тус ажлын хэсгийн хуралдааны үед УИХ-ын гишүүдээс өгсөн үүрэг, чиглэлийн дагуу дараах мэдээллийг бэлтгэн гишүүдийн ажлын албанд тус тус хүргүүлсэн. Үүнд:

- ЭМД-ын сангаас зарцуулж буй тусламж, үйлчилгээний зардал нь хүн амын өвчлөлийн бүтэцтэй хэрхэн уялдаж байгаа талаар
- Эрүүл мэндийн даатгалын сангийн өнөөгийн байдал, орлого, зарлага, сангийн тэнцлийн талаар
- Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг хангахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай.

2025 оны 11.06-ны өдөр ЭМДҮЗ-өөс УИХ-ын ХХНББХ-ны гишүүдийг урьж уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны талаар болон ЭМДС-ын үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, зарчмын шинэчлэлт хийх, даатгалын системийг сайжруулах зэрэг асуудлаар санал солилцсон.

Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн байдал, бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын зөвлөхүүдтэй туршлага солилцлоо.

ЭМДҮЗ-ийн гишүүд, ажлын албаны албан хаагчдыг чадавхжуулах, мэдээ мэдээллээр хангах чиглэлээр гадаад, дотоодын сургалт, уулзалт бусад арга хэмжээнд хамруулах талаар Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Азийн хөгжлийн банкинд албан бичгээр санал хүргүүлсэний дагуу 2025.10.13-ны өдөр Дэлхийн банкны Эрүүл мэндийн зөвлөх Ц.Уранчимэгтэй гишүүдийн төлөөлөл, ажлын албаны дарга нар уулзалт зохион байгуулж, өөрсдийн санал хүсэлтийг танилцуулан, харилцан санал солилцсон.

Олон улсын зөвлөхүүд эрүүл мэндийн даатгалын сангийн менежментийг зөв хийхийн тулд бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтанд мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн холбоодыг түлхүү татан оролцуулах, нотолгоонд суурилан тогтвортой, урт

хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах, мэргэжлийн түвшинд хэлэлцэж, үр дүнг тогтмол үнэлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн ойлголтод хүрсэн.

4.2.ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, онцлох шийдвэрүүд:

ЭМДҮЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлж, анхан шатны тусламж, үйлчилгээг илүү хүн амын эрэлт хэрэгцээнд суурилан хөгжүүлэх, тусламж, үйлчилгээний тэгш байдлыг хангаж шинэчиллээ.

- ✓ 0-18 насны хүүхдүүд, 80-аас дээш ахмадууд болон, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэх үүднээс гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээний багцуудад илүү зорилтот бүлэгт чиглэсэн багцуудыг гаргасан.
- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар өсгөж, орон нутгийн 40 хувийн цалингийн нэмэгдлийн тохируулга хийж тусгалаа.
- ✓ Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хүүхдийн өдрийн эмчилгээний багцийг шинээр үүсгэж, хэрэгжүүлсэн үр дүнг тооцож, өдрийн эмчилгээнд зарцуулах төсвийн 40-өөс доошгүй хувийг хүүхдийн өдрийн эмчилгээнд зарцуулахаар журамласан.
- ✓ Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж, нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар үзүүлж буй эх, нярайн гэрийн идэвхитэй эргэлтийг давхар санхүүжүүлэхээр зохицуулсан.
- ✓ Сувиллаас үзүүлэх хүүхдийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг шинээр үүсгэж анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас илгээх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага үзүүлэх боломжоор хангасан.

ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолоор эх хүүхдийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг бодлогоор дэмжин, дурангын мэс заслыг дэмжих оношийн хамааралтай бүлгийг бий болгож, амбулаторийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгүүдийг шинэчиллээ.

- ✓ Монгол Улсын хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын чиглэлээр кесаров зүслэгээр эхийг төрүүлэхээс бусад төрлийн эх барихын тусламж, үйлчилгээг 80 хүртэлх хувиар, нярайн оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээг 20 хувиар, хүүхдэд үзүүлэх мэс заслын болон эмийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээг 10 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг сайжруулах үүднээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн судалгаанд үндэслэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг амбулаторийн тусламж, үйлчилгээний багцад нэгтгэж, багцыг өргөтгөлөө.

- ✓ Амбулаторийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг дахин зохион байгуулж, нийт оношилгоо шинжилгээг багцлан амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ болгон оношийн хамааралтай бүлэг болгосон.
- ✓ Хор хөнөөл багатай орчин үеийн дэвшилтэт технологи болох дурангийн оношийн хамааралтай бүлгийг нээлттэй мэс заслын оношийн хамааралтай бүлгээс салгаж, 54 оношийн хамааралтай бүлэг үүсгэсэн. Тарифын хувьд бодит өртгийг тооцсоны үндсэн дээр 10 хувиар нэмэгдүүлсэн.

Сангийн тэнцлийг хангах үүднээс эрүүл мэндийн даатгалын сангийн чадамжид нийцсэн тусламж, үйлчилгээг худалдан авах нөхцөлийг бүрдүүллээ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээний өсөлт нь сангийн жилийн төсвөөс давж буй учраас 2023-2024 онд үүссэн өр төлбөрийг үе шаттай бууруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс эмнэлгийн тусламж, үйлчилгээг цочмог өвчний үеийн тусламж, үйлчилгээ, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээ, архаг өвчний үеийн тусламж, үйлчилгээ гэж бүлэглэсэн. Тус өөрчлөлтийн дагуу цочмог үеийн амь нас аврах тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх бол төлөвлөгөөт тусламж, үйлчилгээг гэрээгээр урьдчилан тохиролцож, хэрэв гэрээний дүн хэтэрсэн тохиолдолд төлбөрийн хэмжээний 80 хувиар санхүүжүүлэх, архаг өвчний үеийн тусламж, үйлчилгээг сангийн мөнгөн хөрөнгийн байдалд үндэслэн тодорхой хэмжээгээр худалдах авах ба хэрэв тоо хэмжээ дууссан бол иргэнээс төлбөр авах эрхийг нээж өгсөн.

Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний ЭМДС-ийн тусламж, үйлчилгээний зардалд эзлэх хувийг нэмэгдүүллээ.

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлснээр 2025 онд 90.0 хувьд хүрч, 2020 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

График 6. ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2025 онд зарцуулсан зардал (хувиар)



Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр хорт хавдрын болон яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын тоо өсөж, төрөлжсөн төв эмнэлгийн төвлөрлийг саарууллаа.

Хорт хавдрын тусламж, үйлчилгээ болон яаралтай тусламжийн хувьд хэт их төвлөрсөн байдалтай байсан бол 2025 оны байдлаар хорт хавдрын хими, бай эмчилгээ хийдэг эрүүл мэндийн байгууллагын тоо 37 болж 2 дахин, мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлдэг байгууллагын тоо 2021 онд 5 байсан бол 2025 онд 41 болж 7 дахин, эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага Улаанбаатар хотод 33 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрөл саарсан байдал 2021-2025 он

№	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төрөл	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	Өсөлтийн хувь
1	Хорт хавдар хими, бай	13	16	30	37	37	184.6%
2	Хорт хавдар хөнгөвчлөх	26	37	41	46	46	76.9%
3	Хорт хавдар мэс засал	5	20	38	39	41	720.9%
4	Яаралтай тусламж	54	62	61	61	72	33.3%

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэдийн халааснаас төлөх хэмжээг буурууллаа.

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авч буй иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг хувиар тогтоох нь иргэд санхүүгийн хувьд ядууралд илүү өртдөг тул хамтын төлбөрийн бодлогод өөрчлөлт оруулж, хамтын төлбөрийн хэмжээг хувиар биш тогтмол мөнгөн дүнгээр төлөх хэлбэрт шилжүүлснээр өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд иргэдийн төлөх төлбөрийн хэмжээ буурсан. Тухайлбал, элэг шилжүүлэн суулгах мэс заслын төлбөрийн хэмжээ 113.6 сая, даатгуулагч хувиасаа 28.4 сая төгрөг төлдөг байсныг 5.0 сая төгрөг болгон бууруулснаар халааснаас төлөх төлбөрийн хэмжээ өмнөхөөс 5.7 дахин буурсан.

Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлөх хамтын төлбөрөөс чөлөөллөө.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцдаг иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлснөөр 2021 онд 39 тэрбум, 2022 онд 47 тэрбум төгрөг, 2023 онд 62.8 тэрбум төгрөгийг, 2024 онд 76.8 тэрбум, 2025 онд 80.5 тэрбум төгрөгийг хамтын төлбөрөөс чөлөөлсөн нь 2021 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн байна.

2025 онд нийтдээ 2.78 даатгуулагч тусламж, үйлчилгээ авсан бөгөөд үүнд 164.2 мянган буюу нийт даатгуулагчийн 5.9 хувь нь 2 саяаас дээш санхүүгийн хамгаалалт авсан байна. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь нийт хүн амдаа хүртээмжтэй, тусламж, үйлчилгээг худалдан авхад чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь хүнд өвчтэй даатгуулагчдад санхүүгийн хамгаалалтыг үзүүлж байгааг нотолж байна.

2022 онд даатгалын сангаас хамгийн өндөр санхүүгийн хамгаалалт авсан даатгуулагчийн мөнгөн дүн 126.9 сая төгрөг байсан бол 2025 онд 201.8 сая төгрөг болж, эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байна.

График 7. 2 сая төгрөгөөс дээш санхүүгийн хамгаалалт авсан иргэдийн тоо ба нийт тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид эзлэх хувь



4.3. ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын хэрэгжилтийн явцад хяналт, үнэлгээ хийсэн талаар:

Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийн талаар:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтын мэдээлэлд 2025 оны 1-12 сарын байдлаар төв орон нутгийн 313 эрүүл мэндийн байгууллагаас 10.8 сая тохиолдлын 1.4 их наяд төгрөгийн нэхэмжлэл ирүүлснийг хянасан байна.

А. Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл:

- ✓ төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 9,8 сая тохиолдлын 1,2 (85.4%) тэрбум төгрөг,
- ✓ хувийн хэвшлийн эмнэлэгт 0,9 сая тохиолдлын 181.0 (13.3%) тэрбум төгрөг,
- ✓ рашаан сувилалд 59.8 мянган тохиолдолд 17.1 (1.3) тэрбум төгрөгийг олгохоор тооцсон дүнтэй байна.

Б. Тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл нийт олгохоор тооцсон 1.4 наяд төгрөгийн:

- ✓ 57.5 хувь буюу 782.4 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд,
- ✓ 21.7 хувь буюу 294.9 тэрбум төгрөг амбулаторийн тусламж, үйлчилгээнд,
- ✓ 6.5 хувь буюу 88.5 тэрбум төгрөг өдрийн эмчилгээнд,
- ✓ бусад тусламж, үйлчилгээнд 0.0-3.9 хувь буюу 58,5 сая төгрөгөөс 53.2 тэрбум төгрөг зарцуулагдсан дүнтэй байна.

В. Тохиолдлын тоог авч үзвэл нийт 10.5 мянган тохиолдлын:

- ✓ 68.6 хувь буюу 7.2 сая тохиолдол нь амбулаторийн тусламж, үйлчилгээ
- ✓ 9.4 хувь буюу 993.8 мянган тохиолдол яаралтай тусламж, үйлчилгээ,

- ✓ 6.0 хувь буюу 629.8 мянган тохиолдлыг хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо эзэлж байна.

Нэхэмжлэлийн хяналтын хасагдлын талаар:

Нэхэмжлэлийн хяналтын шалгуур үзүүлэлт хангаагүй улмаас цахим хасагдлаар 34.8 тэрбум төгрөгийн хасалт, эмнэлзүйн нарийвчилсан хяналтаар 91.0 мянган тохиолдлын 26.7 тэрбум төгрөгийн хасалт, эх олонлогоор 25.7 мянган тохиолдолд 9 тэрбум төгрөгийн хасалт хийгдсэн байна.

Б. Нарийвчилсан хяналт болон эх олонлогоор хасагдсан нийт 35.7 тэрбум төгрөгийн хасалтийг эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл:

- ✓ хувь буюу 32.3 тэрбум төгрөгийг улсын эмнэлгүүдийн
- ✓ хувь буюу 3.4 тэрбум төгрөг хувийн эмнэлгүүдийн
- ✓ хувь буюу 12.9 сая төгрөгийг рашаан сувиллын нэхэмжлэлээс тус тус хасагдсан байна.

В. Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт болон эх олонлогийн хасалтаар хасагдсаныг тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл:

- ✓ нийт хасалтын 34.4 хувь буюу 24,3 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс,
- ✓ 10.3 хувь буюу 7.3 тэрбум төгрөг яаралтай тусламжаас хасагдсан дүнтэй байна.

Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлснээс хойш буюу 2020 оноос хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, үнэ, хөнгөлөлттэй эмийн аргачлалыг шинэчилж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг батлан, хэрэгжүүлсэн.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын дагуу 156 өвчний үед хэрэглэх 161 эмэнд хамаарах 651 худалдааны нэршлийн эмэнд 30, 50, 70, 100 хувийн хөнгөлөлт үзүүлж байна. Үүнээс 0-19 хүртэлх насны хүүхдэд уналт, таталт өвчнийг эмчлэх 15 ерөнхий нэршлийн 77 эмэнд, “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийн 15 ерөнхий нэршлийн 26 эмэнд эрүүл мэндийн даатгалаас 100 хувийн хөнгөлөлт олгосон байна.

2025 онд 5.7 сая эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтийг санхүүжүүлсэн бөгөөд эдгээр жорын 1.0 хувийг 100 хувь, 70.0 хувийг 70 хувь, 26 хувийг 50 хувь, 4.0 хувийг 30 хувь тус тус хөнгөлөлт үзүүлсэн байна. Хөнгөлөлттэй эмийн жорын тохиолдлын тоо өмнөх оноос 959.3 мянгаар, санхүүжилт 38.8 тэрбумаар тус тус өссөн байна.

2025 оны байдлаар нийт 784.6 мянган даатгуулагч хөнгөлөлттэй эм авсан буюу Монгол Улсын нийт хүн амын 22.1 хувьд нь хүрч байна. Мөн хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг авч байгаа даатгуулагчийн тоо 2025 онд өмнөх онтой харьцуулахад 22 хувиар, санхүүжилт нь 17 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 12. Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмж

Төрөл	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
А	Б	3	4	5	6	7

Монгол Улсын хүн амын тоо	1	3,357,542	3,409,939	3,457,548	3,504,741	3,544,835
Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчийн тоо	2	406,503	508,837	572,568	645,852	784,603
Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийн хувь, нийт хүн амд тооцсоноор	3	12.10%	14.90%	16.50%	18.40%	22.13%

4.4. Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 38 заалт, УИХ-ын 3 тогтоолын 7 заалт, ЭМДҮЗ-ийн 23 тогтоолын 74 заалт буюу нийт 27 хууль, тогтоомжийн 119 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан. Тогтоол шийдвэрийн биелэлтийн хувь 2025 онд 98.9 хувьтай байна.

Хүснэгт 11. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

№	Хяналтад авсан	Хууль, тогтоомжийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилт /хувиар/
1	ЭМД-ын тухай хууль	1	38	99.6
2	Монгол Улсын Их Хурлын тогтоол	3	7	100.0
3	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	23	74	98.0
Нийт		27	119	98.9

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, хийх журам”-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар үүрэг, чиглэл болгосон 38 заалтын хэрэгжилт 99.6 хувь, Улсын Их Хурлын 3 тогтоолын 7 заалтын хэрэгжилт 100.0 хувь, ЭМДҮЗ-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 23 тогтоолын 74 заалтын хэрэгжилт 98.0 хувь буюу нийт 27 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 119 заалтын хэрэгжилт 98.9 хувьтай байна.

4.5. Бусад

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, баримт бичгийн улсын стандартын дагуу хариутай 28, нийт 135 албан бичиг, 21 өргөдөл, гомдол хүлээн авч, бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, иргэдэд 173 албан бичиг боловсруулан хариу хүргүүлсэн байна.

2025 онд ЭМДҮЗ-ийн батлагдсан төсөв 824.3 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулан, санхүүгийн өр төлбөр, авлагагүй ажилласан байна.

ТАВ. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

5.1. Сангийн яамнаас эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

Сангийн яамны дотоод аудитын нэгжээс Сангийн сайдын 2024 оны СХШХ-09 дугаартай удирдамжийн дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн.

5.1.2 Монгол улсын сангийн яам улсын ахлах байцаагчийн акт (Эрсдэлийн сангийн хөрөнгийг төвлөрүүлэх тухай 2024.11.01, 02/01-09)-ийн биелэлт.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, ЭМДҮЗ-н 2024 оны 1-р сарын 8-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай” 01 дугаар тогтоолын дагуу 2024 оны 12-р сарын 9 өдөр эрсдэлийн санд 53,562,600,000.0 төгрөгийг байршуулсан.

5.1.3 Монгол улсын сангийн яам улсын ахлах байцаагчийн албан шаардлага (Зөрчил арилгуулах тухай 2024.11.01, 02/01-09)-ын биелэлт:

Хуримтлагдсан өр төлбөрийг бууруулах зорилгоор 2025 онд эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээнд тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, төсөв тавьж архаг тусламж, үйлчилгээг тодорхой хувиар хязгаарласан, мөн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээ, диализ, хорт хавдар, яаралтай мэс заслын тусламж, үйлчилгээнээс бусад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээг зогсоож, анхан шатны зарим тусламж, үйлчилгээний төсвийг тодорхой хувиар бууруулах зэрэг хязгаарлалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр, өмнөх оны өглөгийг буурч, 202.6 тэрбум төгрөгийн өглөг үүссэн. 2025 онд дээрх хязгаарлалтын бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр жилийн эцэст олон тэрбум төгрөгийн өглөгө гарах нөхцөлийг арилгасан байна.

Түүнчлэн ЭМДҮЗ-н 2025 оны “төсвийн нарийвчилсан хуваарь батлах тухай” 01, 13, 15, 17 дугаар тогтоолоор төсвийн хуваарийг сар, улирал бүрээр баталж, хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна.

5.1.4 Монгол улсын сангийн яам улсын ахлах байцаагчийн албан шаардлага (Зөрчил арилгуулах тухай 2024.11.08, 02/01-09)-ын биелэлт:

ЭМДЕГ-ын даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/100 дугаар тушаалаар 11 дүгээр тогтоолын шинэчлэлд дэмжлэг үзүүлэх, иргэн даатгуулагчид үзүүлж буй хөнгөлөлттэй эмийн чанар, хүртээмж, санхүүгийн хамгаалалтын талаарх тооцоо, судалгаа хийх, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, ажлын хэсэгт эмийн мэргэжлийн мэргэшсэн холбоодын төлөөллүүдтэй оролцуулж, хамтран ажиллаж байна.

5.1.5 Сангийн яамны дотоод аудитын хорооны тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн биелэлт:

Сангийн яамны дотоод аудитын хорооны тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах 16 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, баталж, хэрэгжилтийг ханган, биелэлтийг улирал тутам Сангийн яаманд хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 93 хувийн гүйцэтгэлтэй байна.

5.2. Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, аудитаар сангийн төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор нийт 76,995.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 175.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 76,820.1 сая төгрөгийн 7 зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.

5.2.1. Албан шаардлага 1139/АО170401 биелэлт:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021.05.11 өдрийн 07/1087 тоот дүгнэлтийг үндэслэн засварын ажлыг гэрээний дагуу гүйцэтгүүлсэн.

5.2.2. Албан шаардлага 954/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:

Агентлагийн даргын баталсан 2025/01 дүгээр удирдамжийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд, Эмийн жагсаалт шинэчлэн батлах тухай ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтэд тус тус дотоод аудит, хяналт-шинжилгээ хийж, дүнг агентлагийн удирдлагууд хэлэлцэж, холбогдох нэгжүүдэд зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж байна

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 2 зөвлөмж, 1 албан шаардлага ирүүлснийг биелэлтийг ханган ажиллаж, заасан хугацаанд нь Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

5.2.3. Аудитын зөвлөмжийн биелэлтийн талаар:

Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас ЭМДСангийн өр төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийг худалдан борлуулах ажлыг эрчимжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны А/06 дугаар тушаалаар байгуулж, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Капитал банкны 136.1 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус банкны эрх хүлээн авагч 15.0 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авсан, 74.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүлээн авсан 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөөс 12.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг борлуулан эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн, 32 аж ахуй нэгж, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулан 1.3 тэрбум төгрөгийн түрээсийн орлогыг санд төвлөрүүлээд байна.

Мөн банкны өр төлбөрт хураагдсан үл хөдлөх хөрөнгийг дахин дуудлага худалдаанд оруулж, худалдан борлуулах ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай болон Ерөнхий сайдын 2025 оны 70 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны 10 дугаар сарын байдлаар 74.0 хувийн хэрэгжилттэй, Үндэсний зөвлөлийн Ажлын албаны зөвлөмжийн биелэлт жилийн эцсийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна.

**ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ,
ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**

6.1. Эрүүл мэндийн даатгалын нөхөн олголт:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад нөхөн төлүүлнэ.” гэж заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 онд 3,815.2 сая төгрөгийн зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 1.5 дахин өссөн байна.

Хүснэгт 14. Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал, 2022-2025 он

Он	Гэм буруутай иргэдийн тоо	Нөхөн төлүүлсэн дүн /мян.төг/
2022	610	281,233.9
2023	1646	1,066,668.6
2024	3421	2,407,566.5
2025	5022	3,815,236.3
Нийт	10699	7,570,705.3

Даатгуулагчийн гомдлын мөрөөр 2025 онд ЭМДЕГ-аас 102 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтыг хийж, иргэн-даатгуулагчийн нэмэлт төлбөр төлсөн мэдээллийг баримт нотолгоонд тулгуурлан бодитой эсэхийг нягтлан шалгаж, тусламж, үйлчилгээ авах үедээ гэрээнд заагаагүй нэмэлт төлбөр авсан 6 иргэний төлбөрийн баримтыг үндэслэн 5,030,800 мянган төгрөгийг буцаан олгуулж, даатгуулагчдыг хохиролгүй болгосон.

Хүснэгт 15. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг)

Буцаан олголт	2022 он		2023 он		2024 он		2025 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Эрүүл мэндийн байгууллага нь эм тариа гаднаас авахуулсан	-	-	5	11,285.4	-	-	2	2,364.6
Гэрээнд тусгагдаагүй нэмэлт төлбөр авсан	12	13,996.4	3	2,323.3	6	455.0	6	5,030.8
Өөр байгууллагад оношилгоо, шинжилгээнд илгээсэн	-	-	3	1,996.2	-	-	-	-
Мессеж мэдээллийн дагуу газар дээрх хяналтаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаанд нь гаднаас авхуулсан эм тарианы мөнгийг буцаан олгуулсан байдал	-	-	9	1,078.9	-	-	-	-
Эрүүл мэндийн даатгалын санд нөхөн төлүүлсэн	-	-	-	-	-	-	5	18,081.9
Шийтгэл ноогдуулсан	-	-	-	-	-	-	8	16,000.0
Нийт	12	13,996.4	20	16,683.7	6	455.0	21	41,477.4

6.2. Эрүүл мэндийн даатгалын цахимжилт

Эрүүл мэндийн даатгалын болон салбарын бодлого, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан цахим системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг тогтмол хийж, мэдээлэл

солилцоо, нэхэмжлэлийн хяналт, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд даатгалын гэрээтэй 2417 байгууллага холбогдсон бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх, хяналт тавих зорилготой эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэн ажилласан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран төрийн мэдээлэл солилцооны ХУР системийн 17 сервис, дан системийн 1 сервисийн хөгжүүлэлт хийж, байгууллагын мэдээлэл шалгах боломжийг бүрдүүлсэн.

Цахим системийн тасралтгүй хөгжүүлэлтийг хангаж, бодлогын өөрчлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцүүлэн, лавлагаа болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээлэл хүлээн авах, нэхэмжлэлийн хяналтыг бүрэн цахимжуулах зорилгоор мэдээлэл солилцох болон баталгаажуулах, төр даах эм, урьдчилан сэргийлэх, хорт хавдрын илрүүлэг зэрэг чиглэлээр нийт 62 сервисийг хөгжүүлсэн.

“Edaatgal” гар утасны аппликейшн болон хиймэл оюунд суурилсан чатбот системийг нэвтрүүлж, нийт 600 гаруй модульд шинэчлэл, сайжруулалт хийсэн.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн зэрэг нийт 301,5 мянган хүн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 44.0 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байна. **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан шимтгэлээ төлсөн даатгуулагчийн тоо өмнөх оноос 14.1 тэрбум төгрөгөөр өссөн сайн үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд цугларсан их өгөгдөл мэдээллийг боловсруулж хяналт хийх, шийдвэр гаргах процесст ашиглах зорилгоор дата боловсруулах хяналтын цахим системийг нэвтрүүлж, нийтдээ 18 тайлан судалгааны зорилгоор “**Tableau систем**”-ийг даатгалын байгууллагын хүрээнд нэвтрүүлэн эмийн борлуулалт болон даатгуулагчийн шимтгэлийн мэдээллийг аппликейшнд харах боломжийг бүрдүүлсэн. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн мэдээллийг нэгтгэн боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, өгөгдлийн чанар, бүрэн бүтэн байдлыг сайжруулсан.

Эрүүл мэндийн даатгалын цахим программыг санхүүгийн **Fiscus** програмтай холбож, даатгалын гэрээтэй аймаг, нийслэлийн 2417 эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн баазыг баяжуулж, 2025 онд гэрээ бүхий байгууллагуудын урьдчилгаа болон эцсийн олгохоор тооцсон санхүүжилттэй холбоотой нийт 62884 нэхэмжлэлийн мэдээллийг Фискус системд илгээсэн.

ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04, болон 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нийт 71 өөрчлөлт, 618 модуль хөгжүүлэлт хийгдэж, гэрээний мэдээллийг шинэчлэн, кодчлолын өөрчлөлтүүдийг нэвтрүүлэн даатгалын сангийн үйл ажиллагааны цахимжилт тасралтгүй, тогтмол үргэлжилсээр байна.

6.3. Сургалт, сурталчилгаа:

Даатгуулагч-иргэдийг тогтмол мэдээллээр хангах чиглэлээр 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 976 контент бэлтгэн түгээсэн нь давхардсан тоогоор 8,436 мянга гаруй хүнд хүрч, 31,620 удаа хуваалцжээ.

Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 138,1 мянган хүн ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандаж, контент хуваалцсан байна.

График 8. Контент хуваалцсан тоо, 2022-2025 он



Сүүлийн 4 жилд давхардсан тоогоор 26,125.4 мянган хүн мэдээлэл авахаар ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандсан байна.

График 9. Бэлтгэсэн контентын тоо, 2023-2025 он




График 10. Контент хандалтын давхардсан тоо, 2022-2025 он



ЭМД-тай холбоотой мэдээ мэдээлэлд мониторинг хийж, цаг алдалгүй хариу арга хэмжээг авч түргэн шуурхай ажилласны үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр эрүүл мэндийн даатгалтай холбоотой 2439 мэдээ, мэдээлэл гаргасан байна.

График 11. ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт




График 12. Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал.



ЭМДЕГ-т мэдээлэл авахаар хуулийн этгээд, иргэнээс хандсан асуудлыг авч үзэхэд санхүүжилттэй 27.2 хувь, даатгалын гэрээ байгуулах, сунгахтай 12.5 хувь,

мэдээллийн технологи 9.6 хувь, нэхэмжлэлийн хяналтын асуудлаар 8.7 хувь, шимтгэл төлөлт 10.1 хувь, өргөдөл гомдол 0.4 хувийг тус тус эзэлж байна.

График 13. ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар:



ДОЛОО. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХАРЬЦУУЛАЛТ

7.1. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

2025 онд ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын хүрээнд лавлагаа шатлалын болон сумын эрүүл мэндийн төвийн зарим тусламж, үйлчилгээг зохицуулж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгон ажиллав. Энэхүү тогтоолын хүрээнд улсын хэмжээнд нийт гэрээ бүхий 314 эрүүл мэндийн байгууллагууд иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, тусламж, үйлчилгээг үзүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллага давхардсан тоогоор 10.5 сая тусламж, үйлчилгээг худалдан авч, 1.360,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

Нийт 10.5 сая тохиолдлын 90.8 хувь буюу 9.6 сая нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас, 8.6 хувь буюу 914.6 мянга нь хувийн хэвшлийн эмнэлгээс, 0.5 хувь буюу 57.9 мянга тохиолдлыг сувиллаас үзүүлсэн байна.

Нийт санхүүжилт болох 1.360,0 тэрбум төгрөгийн 1.177,0 тэрбум (86.6%) төгрөгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад, 165.7 тэрбум (12.2%) төгрөгийг хувийн хэвшлийн эмнэлэгт, 17.1 тэрбум (1.3%) төгрөгийг сувиллаас үзүүлсэн тусламж, үйлчилгээнд олгосон байна.

Хүснэгт 16. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2025 он

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2024 он		2025 он					
		Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тооны өөрчлөлт		Санхүүжилтийн өөрчлөлт	
						Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	722,238	796,955.6	629,868	782,433.7	-92,370	-12.8%	-14,522	-1.8%
	1.1. Мэс засал	171,550	331,563.6	149,099	309,542.4	-22,451	-13.1%	-22,021	-6.6%
	1.2. Эмийн эмчилгээ	519,283	366,326.9	444,070	352,607.2	-75,213	-14.5%	-13,720	-3.7%
	1.3. Эрчимт эмчилгээ	17,509	62,654.4	20,940	85,564.7	3,431	19.6%	22,910	36.6%

	1.4.Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ	13,736	22,231.6	15,584	19,857.0	1,848	13.5%	-2,375	-10.7%
	1.5. Эрхтэн шилжүүлэх мэс засал	160	14,178.9	175	14,862.4	15	9.4%	684	4.8%
	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	7,417,854	300,086.9	7,264,133	294,995.1	-153,721	-2.1%	-5,092	-1.7%
2	2.1. Амбулаторийн үзлэг	3,633,276	83,459.7	3,396,748	71,944.4	-236,528	-6.5%	-11,515	-13.8%
	2.2. Амбулаторийн үзлэг оношилгоо шинжилгээний багц	2,151,156	142,854.2	2,012,493	150,091.2	-138,663	-6.4%	7,237	5.1%
	2.3. Амбулаторийн хяналтын үзлэг	1,046,411	38,930.9	1,095,434	35,422.9	49,023	4.7%	-3,508	-9.0%
	2.4. Амбулаториор хийгдэх мэс ажилбар	66,167	2,598.3	66,953	2,125.6	786	1.2%	-473	-18.2%
	2.5. Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	368,887	23,693.2	290,827	16,986.4	-78,060	-21.2%	-6,707	-28.3%
	2.6. Жирэмсний хяналт	151,957	8,550.5	158,493	12,249.8	6,536	4.3%	3,699	43.3%
	2.7. Сэтгэл зүйн үзлэг, зөвлөгөө			243,185	6,174.9				
	3	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	323,533	28,126.8	174,167	23,480.4	-149,366	-46.2%	-4,646
4	Өдрийн эмчилгээ	156,290	56,979.0	115,370	44,798.0	-40,920	-26.2%	-12,181	-21.4%
	4.1.Өдрийн мэс засал	12,970	4,492.6	10,321	3,956.2	-2,649	-20.4%	-536	-11.9%
	4.2.Өдрийн эмийн эмчилгээ	112,895	30,032.1	68,944	18,857.1	-43,951	-38.9%	-11,175	-37.2%
	4.3.Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ	20,652	9,369.3	23,835	14,613.4	3,183	15.4%	5,244	56.0%
	4.4. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ	9,773	13,084.9	12,270	7,371.2	2,497	25.5%	-5,714	-43.7%
5	Диализын тусламж, үйлчилгээ	251,032	38,703.0	274,762	43,731.7	23,730	9.5%	5,029	13.0%
6	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	300,701	36,519.3	310,269	26,204.8	9,568	3.2%	-10,315	-28.2%
	6.1.Амбулаторийн үзлэг	237,392	5,036.5	266,350	5,514.5	28,958	12.2%	478	9.5%
	6.2.Өдрийн эмчилгээ	20,561	5,865.3	35,343	12,193.6	14,782	71.9%	6,328	107.9%
	6.3.Хэвтүүлэн эмчлэх	42,748	25,617.5	8,576	8,496.7	-34,172	-79.9%	-17,121	-66.8%
7	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	321,516	45,688.1	195,803	28,458.3	-125,713	-39.1%	-17,230	-37.7%
	7.1.Амбулаторийн үзлэг	227,848	4,884.4	140,258	3,059.5	-87,590	-38.4%	-1,825	-37.4%
	7.2.Өдрийн эмчилгээ	24,230	4,052.0	13,384	2,306.2	-10,846	-44.8%	-1,746	-43.1%
	7.3.Хэвтүүлэн эмчлэх	69,438	36,751.8	42,161	23,092.6	-27,277	-39.3%	-13,659	-37.2%
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	8,849	8,564.10	11,785	13,074.3	2,936	33.2%	4,510	52.7%
9	Яаралтай тусламж	920,547	56,358.70	993,858	53,238.7	73,311	8.0%	-3,120	-5.5%
10	Түргэн тусламж	552,601	32,576.80	553,542	32,606.2	941	0.2%	29	0.1%

11	Телемедицинний тусламж, үйлчилгээ	712	38.4	1,006	58.5	294	41.3%	20.1	52.3%
	Сувиллын тусламж, үйлчилгээ	75390	21254.2	59,277	17,306.1	-16113	-21.4%	-3948.1	-18.6%
	Нийт дүн	11,051,263	1,421,850.8	10,583,840	1,360,385.8	-467,423	-4.2%	-61,465	-4.3%

Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоонд эзлэх хувийг харахад хамгийн өндөр нь амбулаторийн ТҮ 68.6 хувийг эзэлж байгаа нь 2024 онд ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ”-ний 8 багцыг шинээр үүсгэж, амбулаторийн тусламж, үйлчилгээний тарифыг 20 хувиар нэмэгдүүлсэн бодлогын өөрчлөлттэй холбоотой.

График 14. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо,



Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ: Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний 629.8 мянган тохиолдолд 782.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээ тохиолдлын тооны 64.5 хувь (406.0 мянга), санхүүжилтийн 39.9 хувь (312.5 тэрбум төгрөг)-ийг, мэс заслын тусламж, үйлчилгээ тохиолдлын тооны 23.7 хувь (149.0 мянга), санхүүжилтийн 39.6 хувь (309.5 тэрбум төгрөг)-ийг эзэлж байна.

Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээнд 15.5 мянган тохиолдолд 19.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Эрхтэн шилжүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээний 175 хүнд 14.8 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд дундаж зардал 84.9 сая төгрөг байна. Эрчимт эмчилгээний 20.9 мянган тохиолдолд 85.5 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд нэг тохиолдлын дундаж зардал 4.0 сая төгрөг байна.

Амбулаторийн тусламж, үйлчилгээ ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний өндөр өртөгтэй болон энгийн багцыг дахин зохион байгуулж, өндөр өртөгтэй болон энгийн багцыг нэгтгэн бүлэглэсэн. Мөн өөр эрүүл мэндийн байгууллагад хийсэн оношилгоо, шинжилгээг ашиглан амбулаторийн цогц тусламж, үйлчилгээг үзүүлсэн тохиолдолд багцын

төлбөрийн хэмжээг тооцохдоо тухайн оношилгоо, шинжилгээний төлбөрийн хэмжээг 20 хувиар тооцон гаргасан бодит зардлыг нэмэгдүүлэн тооцож санхүүжүүлэх зохицуулалт оруулсан. Амбулаторийн хяналтын багцыг оновчтой болгох, эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийг зөв үүсгэх, тогтвортой хяналтыг бий болгох зорилгоор үзлэгийн тарифын өртгийг 10-40 хувиар нэмэгдүүлсэн.

Амбулаторийн тусламж, үйлчилгээний 7.2 сая тохиолдолд 294.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Амбулаторийн үзлэгийн 3.3 сая тохиолдолд 71.9 тэрбум төгрөг олгохоор тооцсон нь амбулаторийн нийт тусламж, үйлчилгээний тохиолдлын 46.8 хувь, санхүүжилтийн 24.4 хувийг, амбулаторийн үзлэг, оношилгоо шинжилгээний багцын тусламж, үйлчилгээнд 2.0 сая тохиолдолд 150.0 тэрбум төгрөгийг олгосон нь тохиолдлын тооны 27.7 хувь, санхүүжилтийн 50.9 хувийг тус тус эзэлж байна.

Амбулаторийн хяналтын үзлэгийн 1.0 сая тохиолдолд 35.4 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон нь нийт үзлэгийн тооны 15.1 хувийг эзэлж байна. Жирэмсний хяналтын багц 158.4 мянган тохиолдолд 12.2 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон нь нийт тохиолдлын 2.2 хувийг, санхүүжилтийн 4.2 хувийг эзэлж байна.

Өдрийн эмчилгээ: Өдрийн эмчилгээний нийт 115,3 мянган тохиолдолд 44.7 тэрбум төгрөгийг олгосон байна. Өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 8.9 хувь, санхүүжилтийн 8.8 хувийг эзэлж байгаа бол өдрийн эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 59.8 хувь, санхүүжилтийн 42.1 хувийг эзэлж байна. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ тохиолдлын 10.6 хувь, санхүүжилтийн 16.5 хувийг эзэлж байна.

Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ: 2025 онд өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд 323.5 мянган тохиолдолд 28.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгосон байна.

Яаралтай тусламж: Яаралтай тусламж, үйлчилгээний нийт 993,8 мянган тохиолдолд 53.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна

7.2. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

Анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор 2023 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг батлахдаа УИХ-аас чиглэл болгож нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан бөгөөд 2024 онд алслагдсан бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй сум, тосгоны эрүүл мэндийн төвийн газарзүйн индексийг нэмэгдүүлснээр эрүүл мэндийн даатгалын сангаас анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй санхүүжилтийн эзлэх хувь нэмэгдсээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 онд анхан шатны 554 эрүүл мэндийн байгууллагуудад 513.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон байна. Үүнээс сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 330 эрүүл мэндийн байгууллагуудад 284.9 тэрбум төгрөгийг, өрхийн эрүүл мэндийн төвийн 225 гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 228.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 17. ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2025 он

№	Анхан шатны тусламж, үйлчилгээ	2023 он	2024 он	2025 он	Өөрчлөлт /2025-2024/	
					Тоогоор	Хувиар
1	Сум, тосгоны ЭМТ-с үзүүлэх тусламж, үйлчилгээ	50,290.40	87,417.3	68,028.1	-19,389.2	-22.2%
1.1	Хэвтүүлэн эмчлэх	30,073.40	48,572.60	34,237.30	14,335.30	-29.5%
1.2	Түргэн тусламж	11,231.70	21,465.10	19,371.50	-2,093.60	-9.8%
1.3	Яаралтай тусламж	5,109.80	10,336.20	7,623.90	-2,712.30	-26.2%
1.4	Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	3,875.50	7,043.40	6,795.40	-248.00	-3.5%
2	Өрх, сум тосгоны ЭМТ-с үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээ	34,083.70	54,526.2	46,217.5	-8,308.7	-15.2%
2.1	Сэргээн засах	9,489.80	14,040.5	12,654.7	-1,385.8	-9.9%
2.1	Өдрийн эмчилгээ	11,343.30	17,506.9	14,392.8	-3,114.1	-17.8%
2.2	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	3,762.50	6,023.1	6,467.6	444.5	7.4%
2.3	Оношилгоо, шинжилгээ	9,488.00	16,955.7	12,702.4	-4,253.3	-25.1%
3	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний санхүүжилт	274,924.40	345,502.50	399,434.4	53,931.9	15.6%
	Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал	359,298.60	487,446.00	513,680.0	26,234.0	5.4%

Нэг иргэнээр тооцсон багц тусламж, үйлчилгээний 2025 оны гүйцэтгэлийг авч үзвэл 20.5%-ийг эмчлэхэд, 31.7%-ийг Халдварт бус өвчний эрт илрүүлэгт, 33.0%-ийг эрүүл мэндийг хянахад, 6.7%-ийг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөхөд, 4.1%-ийг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд, 0.001%-ийг эрүүл мэндийн дэмжихэд, 3.3%-ийг халдварт өвчний эрт илрүүлэгт, 0.7%-ийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 0.02%-ийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ тус тус хийсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, зарим сэргээн засах тусламж, үйлчилгээнд 2025 оны байдлаар 1.1 сая тохиолдолд 46.2 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон байна. Нийт санхүүжилтийн 44.4 тэрбум төгрөг буюу 96.2 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 1.7 тэрбум төгрөг буюу 3.8 хувийг сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 128. ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2025 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр

№	Тусламж, үйлчилгээний төрөл	ӨЭМТ		СТЭМТ		Нийт			
		Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо		Санхүүжилт	
1	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	66,471	6,239.4	3,156	228.2	69,627	5.9%	6,467.6	14.0%
2	Оношилгоо, шинжилгээ	785,069	11,978.7	47,253	723.7	832,322	70.1%	12,702.4	27.5%

3	Өдрийн эмчилгээ	123,732	13,984.7	3,450	408.1	127,182	10.7%	14,392.8	31.1%
4	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	153,457	12,275.4	4,741	379.3	158,198	13.3%	12,654.7	27.4%
Нийт дүн		1,128,729	44,478.3	58,600	1,739.3	1,187,329	100%	46,217.6	100.0%

Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нь авч үзвэл нийт тохиолдлын 3.8 хувийг сум, тосгоны эрүүл мэндийн төв, 96.2 хувийг өрхийн эрүүл мэндийн төв тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаас доорх тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байна. 2025 оны байдлаар 476.6 мянган тохиолдолд 68.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна. Нийт санхүүжилтийн 50.3 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, 28.5 хувийг түргэн тусламж, үйлчилгээ, 11.2 хувийг яаралтай тусламж, үйлчилгээ, 10.0 хувийг шүд амны хөндийн тусламж, үйлчилгээ тус тус эзэлж байна

Хүснэгт 19. СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2025 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр


№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тохиолдлын тоо	Хувиар	Санхүүжилт	Хувиар
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	89,433	18.8%	34,237.3	50.3%
2	Түргэн тусламж	127,792	26.8%	19,371.5	28.5%
3	Яаралтай тусламж, үйлчилгээ	103,848	21.8%	7,623.9	11.2%
4	Шүд амны хөндий	155,580	32.6%	6,795.4	10.0%
Нийт		476,653	100.0%	68,028.1	100.0%

7.3. Эмийн үнийн хөнгөлөлт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ”-г мөрдөж байна.

2025 онд 1550 эмийн сангаар дамжуулан эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 864.6 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 171.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 81.9 мянган хүнээр нэмэгдэж, санхүүжилт 27.2 хувиар өссөн байна.

График 15. Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2025 он, сая төгрөгөөр




Хүснэгт 130. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт 2022-2025 он, сая төгрөгөөр

Төсөв, гүйцэтгэл	2023 он	2024 он	2025 он	Өөрчлөлт /2025-2024/	
				Тоогоор	Хувиар
Төсөв /сая.төг/	89,982.5	137,801.6	171,086.6	33,285.0	24.2%
Гүйцэтгэл /сая.төг/	99,506.5	134,549.6	171,086.0	36,537.0	27.2%
Хамрагдсан хүний тоо	645,360	784,827	864,615.0	79,788	10.2%

Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд 2025 онд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 68.1 хувийг эзэлж байгаа бол хугацаат цэргийн албан хаагч, хүүхдээ асарч буй эх/эцэг, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, ял эдэлж байгаа ялтан санхүүжилтийн хамгийн бага хувийг буюу 0 - 0.03 хувийг эзэлж байна.

Хөнгөлөлттэй эмийн хэрэглээг насны бүлгээр нь авч үзвэл 55-аас дээш насны хүн ам нийт хөнгөлөлт авсан даатгуулагчийн хүн амын 40.9 хувийг эзэлж байгаа нь тус насны бүлгийн хүн амд эмийн хэрэглээ өндөр байна.

График 16. Эмийн үнийн хөнгөлөлт насны ангилалаар 2023-2025 он, сая төгрөгөөр



7.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1-т “Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж байна.

2025 оны байдлаар улсын хэмжээнд 18-аас дээш насны хүн амын 17.1 хувь буюу 152,703 хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдаж 25.3 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна.

Хүснэгт 21. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт, насны багцаар 2023-2025 он

Багц	2023 он		2024 он		2025 он		Өөрчлөлт /2025-2024/	
	Тохиолдол	Санхүүжилт	Тохиолдол	Санхүүжилт	Тохиолдол	Санхүүжилт	Тохиолдол	Санхүүжилт
18-30 насны багц	60,656	3,625.9	37,468	3,104.4	25,693	2,271.9	-11,775	-832.5
31-45 насны багц	130,514	16,067.7	89,200	13,105.0	55,818	10,048.1	-33,382	-3,056.9
46-60 насны багц	113,701	16,044.3	62,880	10,865.3	46,316	8,798.5	-16,564	-2,066.8
61+дээш насны багц	52,516	6,905.0	29,658	4,551.7	24,876	4,245.0	-4,782	-306.7
Нийт	357,387	42,642.9	219,206	31,626.3	152,703	25,363.4	-66,503	-6,262.9

Хамралтыг насны ангиллаар авч үзвэл 18-30 насны залуучуудын 15.2 хувь, 31-45 насны хүн амын 17.6 хувь, 46-60 насны 17.2 хувь, 61-ээс дээш насны хүн амын 18.2 хувь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан дүнтэй байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн 56.6 хувь нь Улаанбаатар хотод, 43.4 хувь нь хөдөө орон нутагт байршилтай эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн байна.

Эрт илрүүлэгт хамрагдалтыг даатгуулагчийн төрлөөр авч үзвэл нийт хамрагдсан хүний 32 хувийг ажил хөдөлмөр эрхэлдэг иргэд, 51 хувийг шимтгэлийг нь төр хариуцах иргэд, 15 хувийг шимтгэлээ өөрөө төлөгч малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, оюутан суралцагсад эзэлж байна.

НАЙМ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Даатгалын сангийн орлого 2025 оны төсвийн тухай хуулиар 2 их наяд 464.3 тэрбум төгрөг батлагдаж, 2 их наяд 299.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, зарцуулалт 2 их наяд 246.2 тэрбум төгрөг болж, цэвэр ашиг (0.02) нэмэх үзүүлэлттэй гарсан.

2. Засгийн газрын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2024 онд 8.4 хувь байсан бол 2025 онд 8.5 хувь болж 0.1 хувиар өссөнч Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.5 пунктээр доогуур байгаа тул Засгийн газрын нийт зардалд эзлэх эрүүл мэндийн салбарын зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна;

3. 2025 онд эрүүл мэндийн улсын зардалд эзлэх ЭМД-ын сангийн зардлын хувь 82.3, эрүүл мэндийн улсын зардалд эзлэх улсын төсвийн шилжүүлгийн хэмжээ 17.7 хувьтай байна;

4. Эрүүл мэндийн даатгалд нийт хүн амын 94.0 хувийг хамруулсан нь “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгасан 2030 оны зорилтот түвшинд хүрээд байна.

5. Анхан шатны тусламж, үйлчилгээ авч буй иргэдийн тоо 2023 онд 2 сая байсан бол 2025 онд 2.1 сая, тохиолдолын тоо 8.7 сая байсан бол 10.7 сая болж хүртээмж нэмэгдсээр байна.

6. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг илүү өргөжүүлж, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудыг нэмэгдүүлэх, хамтын төлбөрөөс чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүд авсанаар 2025 онд нийт тусламж, үйлчилгээний зардлын хамгийн өндөр буюу 90 хувийг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулсан байна.

7. Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогын хүрээнд хамтын төлбөрөөс чөлөөлж санхүүгийн эрсдэлийг хуваалцдаг болсон. Хамтын төлбөрийн чөлөөлөлтөд 2022 онд 47.1 тэрбум, төгрөгийг зарцуулсан бол 2025 онд 80.5 тэрбум болж нэмэгдсэн байна.

8. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн зэрэг нийт 301,5 мянган хүн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 44.0 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байна. **E-Mongolia** болон “**ebarimt**” аппликейшн ашиглан шимтгэлээ төлсөн даатгуулагчийн тоо өмнөх оноос 14.1 тэрбум төгрөгөөр өссөн сайн үзүүлэлттэй байна.

Цаашид анхаарах асуудал, санал

1. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлдөг даатгуулагчдийн шимтгэлийн орлого сангийн орлогын 25.6 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 76.2 хувийг эзэлж байгаа тул төрөөс эрүүл мэндийн даатгалыг хариуцах иргэдийн шимтгэлийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх;

2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг татвар төлж буй орлогын хэмжээтэй уялдуулан тогтоох замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх;

3. Анхан шатны тусламж үйлчилгээний ашиглалтыг 70 хувьд хүргэх замаар лавлагаа шатлалын шаардлагагүй тоо хэмжээг бууруулж, анхан шатны хаалга баригчийн тогтолцоог бэхжүүлэх;

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналтын тогтолцооны реформ хийх, зардлыг хянах, судлах нөхцөл бүрдүүлэх, бүрэн цахимжуулах;

5. Эрүүл мэндийн даатгалын их өгөгдөлийн сан үүсгэх, ашиглах үйл явцын зураглалыг боловсронгуй болгох;

6. Эмийн худалдан авалт, хөнгөлөлтийг шинэчлэх.

--oOo--

**Хавсралт. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2025 оны ээлжит хуралдааны ирц**

/Төлөөлөл бүрээр/

№	ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүн	2025 он		
		Хуралдсан тоо	Оролцсон тоо	Дундаж хувь
Нэг.Засгийн газрын төлөөлөл, дундаж ирц		11	26	80.0%
1	Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга	11	11	100.0%
	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	11	9	82.0%
3	Сангийн сайд	11	6	55%
Хоёр. Даатгуулагчийн төлөөлөл, дундаж ирц		11	26	79%
4	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч	11	4	36%
5	Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга	11	11	100.0%
6	ШУА-ийн харъяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан	11	11	100.0%
Гурав. Ажил олгогчийн төлөөлөл, дундаж ирц		11	32	96.6%
7	Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч	11	11	100.0%
8	Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны УЗ-ийн гишүүн	11	10	90%
9	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн	11	11	100%
Нийт ирц		11	84	85%

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

--oOo--